

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 6
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	7 - 50

1. *Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./*

8 - 50

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Эдийн засгийн байнгын хорооны 10 дугаар сарын 22-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 50 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

*Томилолттой: Р.Сэддорж, О.Батнайрамдал, Х.Ганхуяг, Б.Мөнхсоёл, А.Ундраа;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Энхтүвшин;
Тасалсан: Ж.Алдаржавхлан, Х.Баттулга, Э.Батшугар, С.Цэнгүүн.*

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг “Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг өнөөдрийн Байнгын хорооны хурлын хэлэлцэх асуудлаас хойшлуулах гэсэн горимын санал гаргав.

П.Батчимэг: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 2
Бүгд: 13

84.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч Я.Самбууням, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, Санхүү-нийцлийн

аудитын газрын аудитын менежер Л.Мөнхцацрал, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер Ю.Энхтуяа, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитор Ж.Мөнхбилгүүн, Санхүү-нийцлийн аудитын газрын аудитор Г.Оюунтөгөлдөр, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Үндэсний статистикийн хорооны дэд дарга Д.Лхамсүрэн, мөн хорооны Тамгын газрын дарга Б.Лхагва, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Төмөрхуяг, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга О.Мөнхтөр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч Н.Уранцэцэг, шинжээч Ж.Алтантуяа, Төсвийн зарлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Ю.Содномдаржаа, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Дашням, Төсвийн орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Төгөлдөр, мэргэжилтэн Э.Цолмон, Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн Б.Очиртогтох, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн Р.Хангал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, мөн яамны Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал, Санхүүгийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат, Зам, тээврийн яамны Авто замын бодлого зохицуулалтын газрын дарга Ч.Сугармаа, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Сумъяа, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Баярбат, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ц.Ариунсанаа, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны сайдын зөвлөх О.Амартүвшин, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Тулга, мөн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах дарга Г.Довчинсүрэн, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Н.Нарантуяа, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Жижиг, дунд үйлдвэрийн газрын Бодлого зохицуулалтын хэлтсийн дарга А.Гэрэлзаяа, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, мөн яамны Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга, Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн дарга Б.Мөнх-Оргил нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх О.Одончимэг, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Хатантуул, Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг, референт А.Хонгорзул нар байлцав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Н.Батсүмбэрэл, О.Цогтгэрэл, Ч.Лодойсамбуу, Б.Жаргалан, Л.Соронзонболд, Г.Лувсанжамц, Р.Батболд, Б.Найдалаа нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Баярбат, Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга, Хамтарсан гүйцэтгэх зөвлөлийн дарга Б.Мөнх-Оргил нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

**Нэг.Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд
зардал шилжүүлэх санал:**

П.Батчимэг: 1.Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэгийн гаргасан, Аудитын дүгнэлтийн Орон нутгийн төсвийн хэсэгт 1.1 тэрбум төгрөгөөр санхүү бүртгэлтэй холбоотой ажил гүйцэтгүүлэхээр тусгагдсаныг бууруулах хүрээнд Нийслэлийн суурь зардлыг 600.0 сая төгрөгөөр бууруулж, цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарах, цахилгаанд хүн цохиулахаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох зориулалтаар Эрчим хүчний сайдын урсгал зардлыг 600.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 9
Бүгд: 15
40.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

П.Батчимэг: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 9
Бүгд: 15
40.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Хоёр.Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн багцад тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд өөрчлөлт оруулах санал:

П.Батчимэг: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханы гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтад тусгагдсан XXI.1.8.Налайх дулааны станцын хүчин чадлын өргөтгөл, 185 МВт /Улаанбаатар, Налайх дүүрэг/, Төсөвт өртөг 56,354.9 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 16,900.6 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2025-2027 он гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Налайх Дулааны шинэ эх үүсвэр, 216 МВт, /Улаанбаатар, Налайх дүүрэг/” гэж өөрчилж, уг төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг **18,000.0** сая төгрөгөөр нэмэгдүүлэх, эх үүсвэрийг дараах төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг бууруулах замаар шийдвэрлэх. Үүнд:

- “XV.5.3.1. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын их өгөгдөл, цахим шилжилт, тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **2,000.0** сая төгрөгөөр,
- XVI.1.1.7. Дархан-Алтанбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөл 4 эгнээ, 113.1 километр, гүүрэн байгууламж 885.6 метр /Төвийн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **4,000.0** сая төгрөгөөр,
- XVI.1.1.15. Хэрлэн-Тосон-Уул-Халх гол чиглэлийн хатуу хучилттай авто зам, 256 километр /Зүүн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **2,000.0** сая төгрөгөөр,
- XVI.1.1.19. Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 66 километр /Баруун бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **2,000.0** сая төгрөгөөр,
- XVI.1.2.2. Даланзадгад-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай авто замын их засвар, 156 километр /Говийн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,000.0 сая төгрөгөөр,
XVI.3.1.1. Буйр нуур 4С нисэх буудлын зураг төсөв, барилга угсралт /Зүүн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,000.0 сая төгрөгөөр тус тус бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 12
Бүгд: 15
20.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Гурав.Нэр өөрчлөх санал:

П.Батчимэг: 1. Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтад тусгагдсан XVIII.1.1. Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц /Бүсүүдэд/, төсөвт өртөг 213,199.2 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 63,959.8 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2025-2027 он гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалт-Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүдэд/” гэж өөрчлөх.

2.Төслийн 2 дугаар хавсралтад тусгагдсан XVIII.1.2. Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр 1 дүгээр үе шат /Бүсүүдэд/, төсөвт өртөг 90,000.0 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 30,000.0 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2025-2027 он гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр 1 дүгээр үе шат улс, аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалт-Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүдэд/” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 7
Бүгд: 15
53.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 09 минут үргэлжилж, 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 18 цаг 59 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхим
16 цаг 50 минут

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

П.Батчимэг: Эрхэм Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирц Байнгын хорооны 25 гишүүнээс 13 хүрэлцэн ирсэн байна.

Р.Сэддорж дарга орон нутагт томилолттой, О.Батнайрамдал гишүүн гадаадад томилолттой, Х.Ганхуяг гишүүн гадаадад томилолттой, Б.Мөнхсоёл гишүүн гадаадад томилолттой, А.Ундраа гишүүн гадаадад томилолттой? Д.Энхтүвшин гишүүн гадаадад томилолттой.

Хуралдаанд оролцож байгаа гишүүдээ танилцуулъя.

Н.Алтаншагай гишүүн, М.Бадамсүрэн гишүүн, Р.Батболд гишүүн, Н.Батсүмбэрэл гишүүн, П.Батчимэг гишүүн, Ш.Бямбасүрэн гишүүн, Ж.Ганбаатар гишүүн, Ч.Лодойсамбуу гишүүн, Г.Лувсанжамц гишүүн, М.Мандухай гишүүн, Л.Соронзонболд гишүүн, Б.Найдалаа гишүүн, О.Цогтгэрэл гишүүн.

Ингээд 13 гишүүд хуралдаанд оролцсон. Ирц 52 хувьтай байна.

Ингээд хуралдааныг эхлүүлье.
/алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл.

Хоёрдугаарт, “Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны даргыг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

Ийм хоёр асуудлыг өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхээр тусгагдсан байна.

Дэд хорооны даргыг сонгох асуудлыг Байнгын хорооны дарга нэр дэвшүүлж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзэж байгаа тул өнөөдрийн Байнгын хорооны хэлэлцэх асуудлаас хойшлуулах горимын саналыг гаргаж байна.

Горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Горимын санал 84.6 хувиар дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн учраас дэд хорооны даргыг сонгох тухай асуудлыг өнөөдрийн хэлэлцэх асуудлаас хойшлууллаа.

Ингээд хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай,
Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай,
Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай,
Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд**
/Засгийн газар 2024.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хоёр дахь хэлэлцүүлэг,
Санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэх асуудлын дарааллаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна.

Сайдын микрофоныг нээнэ үү.

Б.Жавхлан: Эрхэм Байнгын хороон дарга, эрхэм гишүүдийн өдрийн мэндийг эрье.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд “Алсын хараа 2050” “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг тогтвортой хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулах, бүсчилсэн хөгжлийг дэмжих татвар, төсвийн бодлогыг хэрэгжүүлэх, авлигыг бууруулж, хүний эрх, засаглалыг сайжруулах зэрэг эрх зүйн 14 реформыг хийж, эдийн засгийн суурийг тэлж, хөгжлийг эрчимжүүлэхийн тулд 14 мега төслийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Ирэх 2025 онд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх

гарааны бүтэн жил учраас ирэх оны төсвийг бүсчилсэн хөгжилд зайлшгүй шаардлагатай суурь дэд бүтцийг шийдэх, орон нутаг бие даан хөгжихөд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдэхэд чиглүүлснээрээ өмнөх жилүүдээс ялгаатай юм.

Шинэ 30 жилийн хөгжлийн суурийг тавих, томоохон төслүүдийг эхлүүлэх, төрийн оролцоог багасгаж, хувийн хэвшлийг дэмжихэд чиглэсэн 2025 оны төсвийн бодлогын 3 онцлогийг дурдъя.

Нэгдүгээрт. Анх удаа бүсчилсэн хөгжлийг бүрэн дэмжсэн төсөв болно.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг 23 жилийн дараа шинэчлэн баталж, газар, түүний баялаг, түүхий эдийн нөөцийг оновчтой ашиглан, хүн ам, үйлдвэрлэлийн зохисгүй бөөгнөрлийг задалж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутгийн тэнцвэргүй байдлыг багасган, хөгжлийн түвшнийг ойртуулж, эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэх эрхэм зорилтыг дэвшүүлсэн билээ.

Энэ хүрээнд Монгол Улсын 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтыг бүсчилсэн хөгжлийг дэмжих, эдийн засгийн интеграцчилал бий болгоход шаардагдах нэн тэргүүний дэд бүтцийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд чиглүүллээ.

Өмнө нь бид хөрөнгө оруулалтыг аймаг, сумдаар жижиглэж төлөвлөдөг байсан бол ирэх 2025 оны төсвийн хөрөнгө оруулалт бүс нутгуудыг хөгжүүлж, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, бүсүүдэд бизнес орчныг сайжруулж, хөрөнгө оруулалт

татах дэд бүтцийн томоохон төслүүдийг чиглүүлэхээр тусгалаа.

Ингэснээр 2028 он гэхэд Монгол Улсын хатуу хучилттай авто зам 4440 километрээр нэмэгдэх бол эрчим хүчний салбарт 1650 мегаватт цахилгаан, дулааны эх үүсвэр шинээр бий болж 1519 километр цахилгаан дамжуулах агаарын шугамыг ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.

Эдгээр хөгжлийн бүтээн байгуулалтуудаас гадна бид нийгмийн хөгжлийн салбарын төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 93 сургууль, 67 цэцэрлэг, 37 эмнэлэг, 22 дотуур байр болон соёл спорт чиглэлийн 60, нийгмийн хамгааллын 17 төслийг ашиглалтад оруулна.

Хоёрдугаарт. Хувийн хэвшлийн оролцоог татварын бодлогоор дэмжинэ.

Бүсчилсэн хөгжлийн дан ганц хөрөнгө оруулалтаар улсаас шийдэх боломжгүй тул бүс нутгийн эдийн засгийн идэвхжилийг дэмжих, бүсийн татварын ялгаатай бодлогыг хэрэгжүүлэхээр тусгалаа.

Энэ хүрээнд 20 гаруй нэр төрлийн татварыг бүсийн онцлогоос хамааран ялгаатай тогтоох боломж бүрдэж, орон нутгийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлж, бүс бие даан хөрөнгө оруулалт татах, эдийн засгийн бодлогоор өрсөлдөх боломжийг бүрдүүлээд байна.

Түүнчлэн бүсчилсэн хөгжлийн зорилтод нийцсэн томоохон бүтээн байгуулалтад хувийн хэвшлийн оролцоог урамшуулан идэвхжүүлжүүлэх бодлого баримталж, томоохон төсөл, арга хэмжээ хөрөнгө оруулалт хийхийг уриалан

дэмжсэн татварын цогц бодлого хэрэгжүүлэхээр төлөвлөлөө.

Гуравдугаарт. *Нийслэлийн тулгамдсан асуудлыг шийднэ.*

Нийслэл хотод сүүлийн 30 жилд нийтдээ 11.5 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж байсан бол ирэх 4 жилд нийтдээ 30 гаруй их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөлөө.

Нэн тэргүүнд түгжрэл, агаар, хөрс, усны бохирдол зэрэг нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдэх зорилгоор 2025 оны төсвийн төсөлд нийслэлд анх удаа 4.5 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр тусгалаа.

Ингэснээр төвлөрлийг сааруулах, нийгмийн суурь үйлчилгээг 20 минутын дотор хүргэх орчин нөхцөлийг бүрдүүлэх, авто замын түгжрэлийг бууруулах арга хэмжээг бодитой хэрэгжүүлэх юм.

Энэ хүрээнд

- *Хөшигийн хөндийн туннел,*
- *“Өөдөө тэмүүлэх Монгол” ган татлагат гүүрийн байгууламжийн мега төслүүдийг Засгийн газрын өрийн баталгаа гаргах,*
- *Засгийн газрын нэг цэгийн үйлчилгээний цогцолборыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх,*
- *Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл метро төсөл,*
- *Туул хурдны зам,*
- *Шинэ тойрог авто замын төслүүдийн нийслэлийн эх үүсвэр болон төр хувийн хэвшлийн түншлэлээр тус тус хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.*

Эдгээр арга хэмжээний үр дүнд агаарын бохирдол 22 орчим хувиар буурч, нийтийн тээврийн хүртээмж нэмэгдэж, түгжрэлийн асуудал шийдэгдэнэ.

Түүнчлэн 37 мянган айлын орон сууц барих дэд бүтцийг бий болгосноор ажлын байр нэмэгдэж, хувийн хэвшил бизнес хийх орчныг сайжруулна гэж үзлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд туссан дээрх бодлогыг хэрэгжүүлснээр

➤ *ирэх онд 83 сая тонн нүүрс, 1.8 сая тонн зэсийн баяжмал экспортолж,*

➤ *гадаад худалдааны нийт эргэлтийг 32.8 тэрбум ам.долларт,*

➤ *эдийн засгийн өсөлтийг 8 хувьд хүргэж,*

➤ *нэгдсэн төсвийн нийт орлогын хэмжээг 36.8 их наяд төгрөгт хүргэхээр тооцооллоо.*

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

П.Батчимэг: Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулгаа хийж дууслаа.

Тэгээд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Ядамын Самбууням танилцуулна.

Микрофоныг өг дөө. Ажлын хэсгийн 4 номер.

Я.Самбууням: Та бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Эдийн засгийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэн аудитын тайлан дүгнэлтийг Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлсэн болно.

Аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулж, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн эсэхийг хянаж үнэлэхэд чиглэсэн болно.

Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эдийн засгийн тулгамдсан болон хугацаа шатсан суурь асуудлуудыг шийдвэрлэж эхлэх, бүсчилсэн хөгжлийн цогц реформын эхний шаг болон нийслэлийн төвлөрлийг сааруулах том төслүүдийг эхлүүлэх зорилт тавьсан байна.

Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд

- *тэнцвэржүүлсэн орлогыг 33 их наяд 864.7 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 35.6 хувь,*
- *нийт зарлагыг 35 их наяд 795.2 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 37.7 хувь,*
- *төсвийн суурь тэнцлийг 1 их наяд 909.5 тэрбум төгрөгийн ашигтай,*
- *төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 1 их наяд 930.5 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувьтай тэнцэж байхаар төлөвлөжээ.*

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг дараах байдалтай төлөвлөжээ. Үүнд:

- *Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын төвлөрүүлэх орлогыг 2.4 тэрбум, зарлагыг 318.3 тэрбум,*

- Санхүүгийн зохицуулах хорооны даргын орлогыг 4 тэрбум, зарлагыг 22.4 тэрбум,
- Үндэсний статистикийн хорооны даргын зарлагыг 36.9 тэрбум,
- Хот байгуулалт, орон сууцжуулалтын сайдын багцыг 494.3 тэрбум төгрөгийн зарлагатай,
- Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын төвлөрүүлэх орлогыг 412.8 тэрбум, зарлагыг 70.8 тэрбум,
- Зам тээврийн сайдын багцыг төвлөрүүлэх орлогыг 110.7 тэрбум, зарлагыг 1 их наяд 645.6 тэрбум,
- Эрчим хүчний сайдын нийт зарлагыг 315.2 тэрбум,
- Монгол Улсын Шадар сайдын багцыг 21.9 тэрбумын орлогыг төвлөрүүлэхээр, зарлахыг 412.3 тэрбум,
- Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын багцын зарлагыг 15.9 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2025 оны төсвийн төслийг 2024 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад төвлөрүүлэх орлогыг 64.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн бөгөөд үүнд

- Санхүүгийн зохицуулах хорооны даргын харьяа төсөвт байгууллагын өөрийн орлогыг 1.3 тэрбум төгрөгөөр,

- Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын төсөвт газрын тосны орлогыг 51.3 тэрбум төгрөгөөр,
- Зам тээврийн сайдын харьяа төсөвт байгууллагын өөрийн орлогыг 5 тэрбум төгрөгөөр,
- Монгол Улсын Шадар сайдын харьяа төсөвт байгууллагуудын өөрийн орлогыг нийт 5.8 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөн нь голлон нөлөөлжээ.

Нийт зарлага ба цэвэр зээлийн хэмжээг 2024 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөв 922.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Үүний шалтгаан нь нэгдүгээрт Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын урсгал зардлын төсвийг 19 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 109.7 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь эд хогшил, урсгал засварын зардлыг 0.7 тэрбум төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хураамжийг 8.4 тэрбум төгрөг, хувийн хэвшлийн байгууллагад олгох дотацийг 9.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөнтэй холбоотой байна.

1. Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын хөрөнгө оруулалтын 4 төсөл, арга хэмжээг нийт 202.6 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд үүнийг улсын төсвөөс санхүүжүүлэх 7 төсөл, арга хэмжээнд 33.9 тэрбум төгрөгийг гадаад зээл, тусламжаар санхүүжүүлэхээр тус тус төлөвлөжээ.

2. Санхүүгийн зохицуулах хорооны даргын урсгал зардлын төсвийг

8.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 22.1 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын зардлыг 7.1 тэрбум төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хураамжийг 0.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөнтэй холбоотой байна.

Санхүүгийн зохицуулах хорооны даргын хөрөнгө оруулалтын төсөвт 1 төсөл, арга хэмжээг 0.3 тэрбум төгрөгөөр улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

3. Үндэсний статистикийн хорооны даргын урсгал зардлын төсвийг 12.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 34.4 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын зардлыг 2.4 тэрбум төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 10.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөснөөс шалтгаалжээ.

Тус төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын төсвийг төсөвт 1 төсөл, арга хэмжээг 2.5 тэрбум төгрөгөөр улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

4. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын урсгал зардлын төсвийг 56.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 101.1 тэрбум төгрөг болгож төлөвлөсөн нь хувийн хэвшилд олгох дотаци санхүүжилтийн зардлыг нэмэгдүүлэн төлөвлөсөн нь голлон нөлөөлжээ.

Тус төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын төсвийг 54 төсөл, арга хэмжээнд 388.1 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 7 төсөл, арга хэмжээнд 354.4 тэрбум төгрөгийг гадаад зээл, тусламжаар санхүүжүүлэхээр тус тус төлөвлөсөн байна.

5. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын урсгал зардлын төсвийг 7.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 29.6 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь мөн цалин хөлс, урамшууллын зардлыг 2.7 тэрбум төгрөг, Засгийн газрын урсгал шилжүүлгийг 3.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвшсөнөөс шалтгаалжээ.

Тус төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын төсөвт 1 төсөл, арга хэмжээ нь 1.2 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 1 төсөл, арга хэмжээний 449.9 тэрбум төгрөгийг гадаад зээл, тусламжаар санхүүжүүлэхээр тус тус төлөвлөжээ.

6. Зам, тээврийн сайдын урсгал зардлын төсвийг 1.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 25.8 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс, урамшууллын зардлыг 0.6 тэрбум төгрөгөөр, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг 0.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлснээс шалтгаалжээ.

Хөрөнгө оруулалтын төсөвт нь 109 төсөл, арга хэмжээнд нийтдээ 1 их наяд 494.2 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 9 төсөл, арга хэмжээнд 132.1 тэрбум төгрөгийг гадаад зээл, тусламжаар санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

7. Эрчим хүчний сайдын урсгал зардлын төсвийг 126.3 тэрбум төгрөгөөр бууруулж, 115.8 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь төрийн өмчийн байгууллагад олгох дотацийн зардлыг бууруулсантай холбоотой байна.

Тус төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтад 37 төсөл, арга хэмжээнд 199.4 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 19 төсөл, арга

хэмжээнд 361.8 тэрбум төгрөгийг гадаад зээл, тусламжаар санхүүжүүлэхээр тус тус төлөвлөсөн байна.

8. Монгол Улсын Шадар сайдын урсгал зардлын төсвийг 85.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 340.7 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын зардлыг 49.9 тэрбум төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ, хураамжийн зардлыг 11 тэрбум төгрөгөөр өсгөсөнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын төсвийг нь 7 төсөл, арга хэмжээнд 47.4 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Монгол Улсын Шадар сайдын урсгал зардлын төсвийг 3.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 8.6 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлын төсвийг нэмэгдүүлснээс голлон нөлөөлжээ.

Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны даргын урсгал зардлын төсвийг 1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 6.7 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд энэ нь цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын зардлыг 0.5 тэрбум төгрөг, байр ашиглалттай холбоотой зардлыг 0.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэнтэй тус тус холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын төсвийг 3 төсөл, арга хэмжээнд 9.2 тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төрийн аудитын байгууллагаас Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын

хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан шалгуурыг хангасан байна гэж дүгнэж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

П.Батчимэг: Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Ядамын Самбууням сая танилцуулгаа хийж дууслаа.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн талаарх товч танилцуулгыг Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт шинжилгээний хэлтсээс бэлтгэн ирүүлснийг Та бүхэнд хүргүүлсэн.

Одоо би ажлын хэсгийг танилцуулъя.

Б.Жавхлан Сангийн сайд, Ц.Туваан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Ж.Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Б.Тулга байхгүй байсан уу Тийм ээ.

Б.Батдаваа Үндэсний статистикийн хорооны дарга, Д.Баярсайхан Санхүүгийн зохицуулах хорооны дарга, И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, С.Жавхланбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, С.Батболд Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Т.Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны

Төрийн нарийн бичгийн дарга, Н.Тавинбэх Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Я.Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч, Ц.Наранчимэг Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор, Д.Энхболд Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор, Л.Мөнхцацрал Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Ю.Энхтуяа Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Ж.Мөнхбилгүүн Санхүү-нийцлийн аудитын газрын аудитор, Г.Оюунтөгөлдөр Санхүү-нийцлийн аудитын газрын аудитор, Т.Жамбаажамц Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга, Үндэсний статистикийн хороо Д.Лхамсүрэн Дэд дарга, Б.Лхагва Тамгын газрын дарга, Б.Төмөрхуяг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Эдийн засаг, хөгжлийн яам Л.Энх-Амгалан Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, О.Мягмардорж Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, О.Мөнхтөр Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн дарга, Сангийн яам М.Санжаадорж Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Б.Тэлмүүн Татварын бодлогын газрын дарга, Г.Золбоо Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, З.Энхболд Хууль, эрх зүйн газрын дарга, Ж.Дэлгэржаргал Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Э.Батмөнх Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Л.Ичинноров Төсвийн орлогын хэлтсийн дарга, П.Бат-Эрдэнэ Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Л.Гантогтох Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Б.Амарбаясгалан Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга, С.Тулга Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Б.Ганзориг Хөгжлийн

санхүүжилтийн хэлтсийн дарга, Н.Уранцэцэг Төсвийн зарлагын хэлтсийн ахлах шинжээч, Ж.Алтантуяа Төсвийн зарлагын хэлтсийн шинжээч, Ю.Содномдаржаа Төсвийн зарлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Б.Дашням Төсвийн нэгтгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Ж.Төгөлдөр Төсвийн орлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Э.Цолмон Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн, Б.Очиртогтох Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн, Р.Хангал Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Б.Анхбаяр Газрын тосны бодлогын газрын дарга, Л.Баярмандал Ашигт малтмал, газрын тосны газрын дарга, Б.Отгонцэцэг Санхүүгийн хэлтсийн дарга, С.Сүхбат Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга, Зам, тээврийн яам Ч.Сугармаа Авто замын бодлого зохицуулалтын газрын дарга, Т.Сумъяа Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам Ц.Баярбат Хот байгуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга, Ц.Ариунсанаа Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, О.Амартүвшин сайдын зөвлөх, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам З.Тулга Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, М.Дондогдорж Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Г.Довчинсүрэн Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах дарга, Н.Нарантуяа Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, Я.Эрдэнэсайхан Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга, А.Гэрэлзаяа Жижиг, дунд үйлдвэрийн газрын Бодлого зохицуулалтын хэлтсийн дарга, Эрчим хүчний яам О.Хуягцогт Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Г.Энхтүвшин Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга.

Ийм бүрэлдэхүүнтэй яамдын төлөөллүүд ирсэн байна.

Ингээд хууль санаачлагчаас болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуух асуулт байна уу?

Асуулттай гишүүд нэрсээ өгнө үү.

Ш.Бадамсүрэн гишүүнээр нэр тасалъя. /алх цохив/

Ж.Ганбаатар гишүүн дарааллын дагуу асуултаа асууя.

Ж.Ганбаатар: Уг нь Эдийн засгийн байнгын хороо төсвийн асуудлыг бусад Байнгын хорооноос түрүүлээд хэлэлцээд их л хурдан дүгнэлтээ гаргаад өгдөг байсан юм.

Тэгээд одоо хамгийн сүүлд нь шахуу хэлэлцэж байх юм. Хоёрдугаар хэлэлцүүлгийг ярьсан шүү.

Улсын төсвийн зардал талаас би Сангийн сайдаас асуулт байна.

2016 онд анх гишүүн болж байхад улсын төсвийн зардал 7 их наяд төгрөг л байсан юм л даа.

Тэгээд жил болгон л би асуудаг юм л даа. Жил болгон л асуудаг юм.

2025 онд чинь хэд вэ 26 их наяд. 2016 онд 7 их наяд байсан гээд бодоорой. Өнөөдөр 26 их наяд.

Тэгээд улсын төсвийн зардал талд ер нь ямар шинэчлэлт хийх вэ? Улс хөгжинө өө гэвэл уг нь урсгал зардал биш, хөрөнгө оруулалтын зардал урсгал

зардлаасаа хавьгүй их байж л улс хөгждөг. Бүгд мэдэж байгаа.

Тэгээд би энэ жил ганцхан асуугаад байгаа юм биш. Жил болгон л асуудаг байсан асуудлаа асууя.

Энэ дээр ямар дүгнэлт тавьж байна аа? Хэзээ манайх урсгал зардал нь хөрөнгө оруулалтынхаа зардлаас бага гарч вэ?

Урсгал зардлын нэмэгдэл. Ялангуяа 2025 оны их нэмэгдэл юунаас шалтгаалсан бэ? Дулаан, цахилгааны үнэ юм уу? Эсвэл бид буруу зүйлд хөрөнгө оруулаад байгаа юм уу? Төсвийн хөрөнгийг буруу зарцуулаад урсгал зардал нэмэгдээд байгаа юм уу?

Энэ дотор нь хөрөнгийн зардал гээд маш том зардал явж байх юм.

Ингээд дэлгэрэнгүй яривал миний минут хүрэхгүй байх.

Нүүрсний экспортыг Б.Жавхлан сайд санаж байгаа л даа чинь.

Би сайд байхдаа 60 сая тонн манай салбар гаргаж чадна гээд өгсөн юм. 4 сард байх аа даа. 2024 оны.

2023 онд бас нэг тоо авдаг. Хоёулан дээр нь ер нь 60 сая тонн л салбар хүчин чадлын хүрээнд. Энэ чинь ганцхан салбараа бодохоос гадна яам тоогоо гаргаж өгөхдөө бүх хүчин зүйлүүдийг тооцсон л доо.

Ложистик, экспорт, хүлээн авах гэж байгаа улсын. Олон зүйлийг харгалзаад. Хил, гаалийн хүчин чадал гээд.

Тэгээд 83 гэдэг тоог хэн зассан бэ? Мэргэжлийн яам 60 сая гэдэг тоо гаргаж өгсөн. Тэгээд яагаад 83 болчхов оо?

Зүгээр яах вэ, энэ дээр нэг зүйл хэлэхэд 83 гэхээр ганцхан экспорт.../минут дуусав/

П.Батчимэг: Б.Жавхлан сайд хариулах уу? 5 номерын микрофон.

Б.Жавхлан: Ж.Ганбаатар гишүүний асуултад хариулья.

Төсвийн бодлого, мөнгөний бодлого макро хоёр гол суурь бодлого маань Эдийн засгийн хөгжлийг дэмжих үндсэн нэг багана үүрэг нь ийм байдаг.

Тэгэхээр 2019 онд буюу яг ковидын өмнөх жил дотоодын нийт бүтээгдэхүүн 36 их наяд байсан юм.

Ирэх жил дотоодын нийт бүтээгдэхүүн 95 их наядаас дээш давахаар байгаа.

Өөрөөр хэлбэл үндсэндээ **GDP 3.7** дахин нэмэгдэж байна гэсэн үг.

Мөн төсөв ч гэсэн ер нь дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 34-өөс 36 хувийн харьцаатай. Өөрөөр хэлбэл гуравны нэг ийм реал шоттой явж ирж байгаа.

Тэгэхээр өөрөөр хэлбэл төсөв маань өөрөө дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг дэмжих мөнгөний үржүүлэгч байх ийм үндсэн үүрэг, энэ харьцаа нь хадгалагдаад явж байна гэж хэлж болно.

Төсвийн урсгал зардал ер нь төсвийн хөрөнгө оруулалтаас өөрөө шууд шалтгаалдаг.

Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалт хэдий чинээ хийгдэж байна тэр хэмжээгээр урсгал зардал нэмэгдэж байдаг.

Гэхдээ үүний харьцааг урсгал зардлыг аль болох өсөлтийг нь багасгах, үүнийг хүний оролцоог нь багасгах, цахимжуулах, ил тод болгох, нээлттэй хүртээмжтэй болгох гээд, технологи дагасан ч гэдэг юм уу ийм зүйлүүд.

Мөн хувийн хэвшлээр хийлгүүлж болох урсгал зардлаар санхүүжүүлээд явах зүйлүүдийг төсвөөс гаргах ч гэдэг юм уу, ийм төсвийн шинэчлэлүүд сүүлийн жилүүдэд таныг байх үед ч гэсэн бид хийгээд явж байгаа.

Цаашдаа ч энэ үргэлжлээд явах юм.

2025 оны төсвийн зардал талын нэмэгдэл нь нийтдээ 5.3 их наяд байгаа.

5.3-ын 1.7 нь “хөрөнгийн зардал” буюу “хөрөнгө оруулалтын өсөлт” ирэх жилийнхээс.

Цаана нь байгаа 3.5 их наядын ерөөсөө 2.5 буюу бараг 70 хувь нь хүн амын статистик өсөлт.

Тариф, инфляцын өсөлттэй холбоотой 70 хувь. Үлдсэн 30 хувь нь хууль тогтоомжийн өөрчлөлт, хууль тогтоомжид заасны дагуу шууд нэмэгдэж байгаа зардал.

Мөн 14 орчим хувийн зардлын өсөлт нь үндэсний хэмжээний үндсэндээ 4 том төсөл байгаа.

- ▷ “Цагаан алт”,
- ▷ “Хүнсний хувьсгал”,
- ▷ “Атрын IV аян”.

Ийм үндэсний төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах төслийн урсгал зардал нэмэгдэж байгаатай холбоотой.

Ерөөсөө л ийм 3 эдийн засгийн ангиллаар зардал нэмэгдэж байгаа зүйлүүд байгаа юм.

Үүнийг задлаад харвал Та бүхэнд хүргэсэн төсвийн ном дээр маш дэлгэрэнгүй байгаа.

Эдийн засгийн хөгжлийн яамнаас нэмж хариулна биз. 60 сая тонн нүүрсийг тэр 83 гээд.

Энэ жилийн гүйцэтгэл үндсэндээ жилийн эцэс рүү 82 руу нэлээн дөхөх нь. Одоо тооцоолж байгаагаар ер нь 78 сая тонн хүрэхээр байгаа. Амжилттай явбал 80 сая тонн энэ жил хүрэхээр байна.

Тэгэхээр өөрөөр хэлбэл олборлох чадвар, дээрээс нь хилийн нэвтрэн өнгөрүүлэх болон тээвэрлэх боломж маань сүүлийн жилүүдэд боомтын сэргэлтийн хүрээнд боломжийн шат шатаараа нэмэгдсэн байна.

Тийм учраас ирэх жил энэ жил гаргаж байгаагаа л бид ямар ч байсан ирэх жил гаргачихъя л гэсэн ийм бас нэлээн даруу тоо гэж харж байгаа.

Гол манай экспортыг хүлээж авч байгаа урд хөрш маань, хэрэглэгч маань

→ *танайх хэчнээнийг олборлож чадна,*

→ *хэчнээнийг тээвэрлэж чадна,*

→ *хэчнээнийг хилээр нэвтрүүлж чадна*

“тэр хэмжээгээр бид авна” гэдгийгээ мэдэгдэж байгаа.

Тийм учраас биет хэмжээний хувьд энэ боломжийн төсөвлөсөн гэж харж байна.

Эдийн засгийн хөгжлийн яамнаас нэмж мэдээллээ өгөөрэй. Тийм.

П.Батчимэг: Ж.Ганбаатар гишүүн тодруулга.

Ж.Ганбаатар: Тамгын газрынхан. Энэ чинь асуулт нь 3 минут, хариулт нь 4 минут.

Тэгээд тодруулга болгонд л хариулна шүү дээ. Наадах чинь ийм хууль арай үгүй байх аа. Наадхаа нэг тодруулахгүй бол.

Тэгээд энэ зардлыг жил болгон ярьдаг л даа. Ийм урсгал зардалтай улс үнэхээр маш ховор юм билээ шүү. Бүгдээрээ үүнийг олон удаа ярьдаг. Үүнийгээ сайн анхаарна биз дээ.

Ийм урсгал зардалтай компани оршин тогтнох боломж байхгүй шүү дээ. Энэ бол ерөөсөө цаашаа хөгжих ямар ч боломж байхгүй. Энэ бол хамгийн том гажуудал гэсэн үг.

Дээрээс нь нэг зүйл хэлэхэд. Ер нь зүгээр Б.Жавхлан сайдад хандаж хэлэхэд хүмүүс яах вэ экспортын орлого нь буугаасай, доллар нь яагаасай гэсэн хүмүүс байх шиг байгаа юм. Хүсэлтэй хүмүүс. Одоо хорлож бодож байна шүү дээ.

Би бол одоо энэ чинь наад нүүрсээ биржээрээ зараач ээ, зэсээ биржээрээ зараач ээ, мөнгө олох боломж байна шүү

дээ. Ж.Ганбат дарга ойлгож байгаа. Үүнийг.

П.Батчимэг: Ж.Ганбаатар гишүүнд 1 минут.

Ж.Ганбаатар: Хуулийн дагуу авсан шүү. Тийм.

Тэгээд ер нь тэр экспортыг нэмэгдүүлэх талд нь л санаа зовж байгаа. Б.Жавхлан сайд аа.

Зүгээр ингээд хэвлэл мэдээллийг юм уу, зарим нэг хүмүүсийг харж байхад ирэх жил ер нь их балрах юм байна гэсэн бодолтой хүмүүс их байх шиг байгаа юм.

Тийм учраас уг нь бид нарт боломж байна.

Нүүрсний экспортыг би хийхгүй байна гэж хэлэхгүй байгаа шүү дээ. Багасгаад байна. Уг нь наадах чинь нэмэгдэх ёстой. 100 хувь байх ёстой. Ж.Ганбат дарга мэдэж байгаа.

Тэр 4 компани гээд томроод байна лээ. Бэлэн мөнгөөр зарж байгаа гэж. Тэр чинь биржээр зарах ёстой шүү дээ. Тэрийг цуцлах хэрэгтэй.

Тэр чинь одоо ингээд 2 жил болчихлоо. Одоо хангалттай шүү дээ. Тэр.

Одоо тэр нөхдүүд биржээр нүүрсээ авах ёстой. Зэсээ биржээр зарах хэрэгтэй. Ингэж байж бид мөнгөтэй болно гэдгийг анхааруулж хэлье. Баярлалаа.

Асуулт асуусангүй. Үг хэллээ.

П.Батчимэг: Н.Батсүмбэрэл гишүүн асуулт.

Н.Батсүмбэрэл: Эдийн засаг, хөгжлийн яамнаас асууя.

Ж.Ганбаатар гишүүний яриад байгаа тэр төсөв, урсгал зардал нэмэгдээд байгаа байдалтай санал нэг байгаа.

Үүнийг ер нь багасгах учиртай. Бидний өмнө тулгамдаж байгаа нэг том асуудал бол энэ орон нутгийн засаг захиргааны нэгжийг шинэчлэн зохион байгуулах асуудал байгаа.

Хэд хэдэн удаа асуудлыг хөндсөн.

Эдийн засгийн яаман дээр “дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын орчин тодорхой болно” гэсэн “зорилт дэвшүүлсэн” байгаа.

➤ Энэ дотор Та бүхний урсгал зардалд Монгол Улсад байгаа хэрэгтэй хэрэггүй сум, суурин, захиргаадыг нэгтгэх, шинэчлэн зохион байгуулах судалгааг хийх үү? Ийм судалгаа байгаа юу? Үүнийг асуулт авъя. **Нэгдүгээрт.**

➤ **Хоёрдугаарт,** бүтцийн хэмнэлт хийж болох газрууд харагдаад байгаа. Үүнийг Сангийн яам судалж байна уу?

Б.Жавхлан сайд энэ дээр тодорхой хариулт өгмөөр байна.

Би тодруулаад бүр нэр цохоод асуувал Статистикийн газар.

Статистикийн газар дээр “Нийслэлийн статистикийн газар” гээд ямар ч хэрэггүй дамжуулагч байгууллага байна.

Үүнийгээ татан буулгаач та нар. Яагаад татан буулгадаггүй юм. Нэг хүний хамаатан тавьчихсан юм уу, хаашаа юм.

Оронд нь дүүргүүд дээр байгаа Статистикийн хэлтсүүдээ газар болгоод тэр Нийслэлийн газарт байгаа хүмүүсээ шилжүүлээд, мэдлийг нь өгөөд ажлыг нь хийлгэвэл яасан юм.

Дүүрэг дээр байгаа мэдээг Ерөнхий газар луу заавал Нийслэлийн газраар дамжуулах шаардлага юу байгаа юм?

Яг ийм давхардсан бүтэц байгаа. Тэгээд ажлууд дээр судалгаа Нийслэлийн захиргаа хийж байна уу? Хотын захиргаа.

Тэгээд энэ асуултууд дээр хариулт авъя.

Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яам, Хотын захиргаа, Статистикийн газар.

Тэр статистикийн нийслэлийн газраа хэзээ татан буулгах юм?

П.Батчимэг: Н.Батсүмбэрэл гишүүний асуусан асуултад хариулт.

Ажлын хэсгийн 3 номерын микрофоныг өг дөө.

И.Батхүү: Н.Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя.

Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү.

Хүн амын нутагшил, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах ажлын үр дүнд сумдыг нэгтгэх асуудлыг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл

баримтлалтай уялдуулаад тусгаж баталсан байгаа.

Нийслэл, аймаг бүрд орон нутгийн хөгжлийн 90 төвийг тодорхойлж гаргасан байгаа.

Үүнтэй холбоотой нэмэлт судалгааг “бүсчилсэн хөгжлийн асуудал” хариуцсан Шадар сайдын 2024 оны төсвийн тодотголоор 60 тэрбумын санхүүжилт батлагдсан байгаа. Энэ хүрээнд тодорхой ажлууд хийгдэнэ гэж үзэж байгаа.

Нэмэлтээр Шадар сайдын ажлын албанаас хариулах байх аа.

П.Батчимэг: Сангийн сайд хариулах уу? Ажлын хэсгийн 5 номер.

Б.Жавхлан: Баярлалаа. Н.Батсүмбэрэл гишүүний асуултад.

Засгийн газрын бүтэц болон төсвийн ерөнхийлөн захирагч, сайд нарын чиг үүрэгт давхардал юу байна? Энэ дээр шаардлагатай арга хэмжээнүүдийг авах тал дээр Засгийн газар. Энэ чинь бүр яг үүнийгээ дагнасан манайх чинь бүр сайдтай болсон шүү дээ.

Тэгээд хяналт шалгалтын чиг үүрэг гүйцэтгэж байгаа болон Хэрэг эрхлэх газар дээрээс энэ дээр үнэлгээ хийгдэж байгаа.

Тэгээд тодорхой үр дүн гараад давхардал хаанаа ямар үүрэг функцийн хувьд байна, нэмэх зүйл байна уу, хасах зүйл байна уу. Энэ зүйлүүд нь тодорхой болсны дараа дэлгэрэнгүй мэдээлэл өгье. Тийм. Яг энэ асуудал яригдаж байгаа, хяналт шалгалт хийгдэж байгаа.

П.Батчимэг: Б.Батдаваа дарга 2 номерын микрофон дээр ирээд асуултад хариулья.

Б.Батдаваа: Н.Батсүмбэрэл гишүүний асуултад хариулья.

Үндэсний статистикийн хороо гишүүний хэлсэнтэй санал нэг байгаа. Яагаад гэхээр олон улсын зөвлөмж, бидний гаргасан шинжилгээгээр бид төв рүүгээ илүү дата шинжилгээний ур чадвараа сайжруулах, хуучин уламжлалт аргаар буюу засаг захиргааны нэгжээс шууд мэдээлэл цаасаар цуглуулах энэ үйл ажиллагаанаасаа татгалзахаар явж байгаа.

Энэ ажлын хүрээнд бид 2022, 2023 онд Нийслэлийн статистикийн газар болон дүүргүүдээс тодорхой хэмжээний орон тоог төвлөрүүлэх, давхардлыг арилгах арга хэмжээг авсан.

Цаашдаа энэ ажлаа бид үргэлжлүүлээд хийнэ.

Энэ дээр бас хуулийн зохицуулалт дээр өөрчлөлт оруулах зүйл байгаа.

Статистикийн тухай хууль дээр аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд статистикийн газар, хэлтэс байна гэсэн ийм зүйл байгаа.

Үүнийг бид хуулийн шинэчлэлийнхээ хүрээнд Эдийн засгийн байнгын хорооны гишүүдэд танилцуулах үеэр танилцуулж байсан. Үүнийгээ оруулаад.../минут дуусав/

П.Батчимэг: Шадар сайдын ажлын албанаас 2 номерын микрофон дээр Н.Батсүмбэрэл гишүүний асуултад хариулья.

Нэр албан тушаалаа хэлээрэй. Шадар сайдын ажлын алба.

Б.Мөнх-Оргил: 2024 оны төсвийн тодотголд 60.0 тэрбум төгрөгийн төсвөөс техник, эдийн засгийн үндэслэлтэй холбоотойгоор төсөв тавигдсан.

Төсвийг бид хуулийн хугацаанд энэ онд нь сонгон шалгаруулалт хийж, хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, зураг төсвийн ажлыг зохион байгуулахаар ажиллаж байгаа.

Одоо 11 сарын 26-нд Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газартайгаа хамтарч хууль тогтоогч нартай холбогдох мэдээллийг өгөхөөр энэ хагас сайн өдөр бид бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Ирэх онд бүсчилсэн хөгжлийн чиглэлээр яг тухайлан бүсүүдийн хэмжээнд зураг төсөлтэй холбоотой санхүүжилт Эдийн засаг, хөгжлийн яаман дээр 40.0 тэрбум төгрөгийн төсөл тавигдсан.

Манай бүсчилсэн хөгжлийн чиглэлээр зураг төсвийн ажил тавигдаагүй байгаа.

Энэ онд 60.0 тэрбум төгрөгийн техник, эдийн засгийн үндэслэлийн зардал тавигдсан. 2024 оны зардал дээр.

П.Батчимэг: Н.Батсүмбэрэл гишүүн тодруулга байна уу? Тодруулья.

Н.Батсүмбэрэл: Тэгэхээр бид нарт ХХ зууны техник, эдийн засаг, нөөц бололцоо дээр тулгуурласан 300 гаруй сум байна.

Бид одоо XXI зууны эдийн засгийн үзүүлэлт, техникийн хүчин чадалтай болчихсон.

Тэгэхээр Монгол Улсад шаардлагатай юу, энэ 330 сум. Яг 330 Засаг дарга, 330 хурлын дарга хэрэгтэй юу? 8031 иргэдийн хурлын төлөөлөгч хэрэгтэй юу гэдгийг судлаад гаргаад өгөөч л гэж байгаа шүү дээ.

Тэгэхээр урдаас техник, эдийн засгийн үндэслэл, үзүүлэлт яриад байх юм.

Үүнийгээ жоохон бодитой хийж танилцуулж болох уу?

П.Батчимэг: Ажлын хэсгийн 2 номер. Нэр албан тушаалаа хэл дээ.

Б.Мөнх-Оргил: Шадар сайдын ахлах зөвлөх Ц.Мөнх-Оргил.

Холбогдох мэдээллийг гишүүнд албан шугамаар нь хүргүүлье. Дэлгэрэнгүй мэдээллийг.

П.Батчимэг: Н.Батсүмбэрэл гишүүнд 1 минут.

Н.Батсүмбэрэл: Тэгэхээр И.Батхүү дарга, Б.Мөнх-Оргил дарга нар бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд сум, суурингуудын асуудлыг тусгайлж судалж нэг бодитой санал оруулж ирмээр байна.

Сайд нар нь хуралд байхгүй. Тэгээд орлогч нар ирчихсэн. Тэгээд орлогч нарт мэдэл байхгүй, шийдэл байхгүй, эрх байхгүй, үг байхгүй асуугаад байж таарахгүй.

Сайд нартаа хэлцгээгээрэй. Бодитой албан санал албан бичгээр өгөөрэй.

Тэгээд сайд нар нь байхгүй. Тэгээд орлогч нар дандаа. Хүн орлож сууж байгаа. Мэдээд юм ярьж чаддаггүй. Хамаагүй юм хэлж чадахгүй энэ байдлыг тасалмаар байна.

П.Батчимэг: Н.Батсүмбэрэл гишүүн асуулт биш санал хэллээ.

Дараагийн О.Цогтгэрэл гишүүнд асуулт асууя.

О.Цогтгэрэл: 2025 оны төсвийн төсөл, нэгдсэн төсөв, түүнд хийсэн аудитын дүгнэлтийг харж байна.

Монгол Улсын Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх нь Монгол Улсын дараа жилийн төсвийг хэлэлцэн батлах.

Тэгэхээр яг энэ тараагдсан бичиг цааснаас гадна би аудитаас онцгойлж асуух гээд байгаа нь төсвөөс гадуур төсөв Монгол Улсад өнгөрсөн жилүүдэд явж ирсэн.

Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд халдсан, Улсын Их Хурлаар хэлэлцэн батлагддаггүй.

Жишээ нь, “Эрдэнэс Тавантолгой” компаниас бараг **2 их наядыг** нь хөрөнгө оруулалт гэх үү, зээл гэх үү, шилжүүлэг гэх үү “утаагүй түлшний үйлдвэр” лүү хийчхэж байсан.

Тэр нүүрс, нефть дамжуулах хоолой гээд хэдэн их наядын ч төсөл байна.

Бүр Багануурын нүүрсний уурхайд зээл өгсөн гээд л. Бүр банк, санхүүгийн үйл ажиллагааг хүртэл явуулаад.

Уг нь энэ мөнгөнүүд чинь улсын төсөвт татвар, ногдол ашиг, бусад хэлбэрээр улсын төсөвт орлого талдаа нэгтгэгдээд Улсын Их Хурал дээр хэлэлцэн батлах ёстой.

Жишээ нь, “Эрдэнэт” үйлдвэр сургуулиудын жорлон барина, “Эрдэнэт” үйлдвэрээс 1.4 их наядар цахилгаан дулааныг тэглэнэ. Энд ямарваа нэгэн Улсын Их Хурлын шийдвэргүйгээр буюу ингээд үзэхээр энэ дүн чинь нэлээн олон их наядын тоо гарна.

Гэтэл энэ төсөв дээр байгаагаар жилийн Монгол Улсын 2025 оны хөрөнгө оруулалтыг бид 3 их наядын хөрөнгө оруулалтыг тойрч ярих гээд байгаа юм.

Түүнээс чинь хэд дахин их мөнгийг улсын төсвөөс гадуур зарцуулаад байгаа юм.

Энэ дээр Монгол Улсын аудитын байгууллага ямар дүгнэлттэй байдаг юм. Энэ ер нь зөв юм уу, буруу юм уу? Буруу бол та нар ямар акт, дүгнэлт тавьж байсан юм?

Хэрвээ буруу бол энэ дээр эрх бүхий байгууллага нь Улсын Их Хурал ямар тогтоол шийдвэр гаргах ёстой гэж Та бүхэн энэ бодлогын зөвлөмж, энэ олон зүйл дээрээ бичсэн юм? Би лав тийм юм олж харсангүй.

Тэгэхээр Та энэ дээрээ тодорхой хариултууд өгөөч. Жил дамнан ужгираад ирсэн. Тэгэхдээ тоог нь л танд хэлье.

Бид бүгдийн 45 хоног парламентаар хэлэлцэж байгаа төсвийн

хөрөнгө оруулалтаас хэд дахин их мөнгө төсвийн гадуур шийдэгдээд, тэнд Засгийн газрын тогтоол, магадгүй тэр Төрийн өмчийн хороо нь байдаг юм уу, Бодлого зохицуулалтын газар, тэгээд магадгүй тодорхой хэмжээний эрх бүхий ажилтнуудын шийдвэрээр Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд халдаад байна гэдэг л асуудлыг.

Та бүхэн энэ дээр тодорхой дүгнэлтүүдээ, байр сууриа, авах арга хэмжээ, авч байсан арга хэмжээгээ хэлж өгөөч.

П.Батчимэг: Сангийн сайд. Ажлын хэсгийн 5 номерын микрофон.

4 номер. Аудит.

Я.Самбууням: О.Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Я.Самбууням байна.

Бид өмнөх онуудад буюу Засгийн газрын нэгдсэн тайланг жил бүхэн Засгийн газрын нэгдсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийдэг.

Энэ хүрээнд бид төрийн өмчит компаниудаас төсвийн дансаар дамжихгүйгээр шууд зарцуулалт хийж байгаа асуудал дээр нь сөрөг дүгнэлтүүдийг өгч явж байсан.

Тухайлбал, ковидын үед “Эрдэнэт” төрийн өмчит үйлдвэрийн газраас уур ус, цахилгааны төлбөрийг хариуцаж төлж байсан 1 их наядын төлбөр байгаа.

Мөн “Эрдэнэс Тавантолгой”-той холбогдуулан төсвөөс гадуур зарцуулагдаад байгаа.

Энэ нь ямарваа нэгэн хэлбэрээр төсвөөр буюу татвар хураамжаар төсөвт төвлөрч байж Их Хурлаас төсвөө батлуулж зарцуулах ёстой гэдэг дүгнэлтийг өгсөн.

Энэ хүрээнд Их Хурал болон Засгийн газарт зөвлөмжүүдийг хүргүүлж ажиллаж байсан.

П.Батчимэг: О.Цогтгэрэл гишүүн тодруулга.

О.Цогтгэрэл: Аудитын байгууллагын удирдлагад талархлаа гэх үү, бас тодорхой хэмжээгээр “хууль зөрчсөн үйлдэл” өнгөрсөн жилүүдэд явж иржээ гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

Нөгөө талаараа бид энд нэг ийм “зөвлөмж өгсөн” гэдэг чинь уг нь танай байгууллагын эрх, чиг үүрэгт энэ төдий.

Гүйцэтгэх засаглал Монгол Улсын хуулийг зөрчихөөд явж байхад “зөвлөмж өгсөн” гэдэг төдий эрх үүрэг, авах ёстой арга хэмжээ ч ийм биш байдаг байх гэж бодож байна.

Тэгээд аудитын байгууллагаас албан ёсоор Монгол Улсын хуулийг гүйцэтгэх засаглал зөрчиж байна гэдэг дүгнэлт гаргаж байна.

Тэгээд энэ дээр цааш цаашдаа Улсын Их Хурал, Улсын Их Хурлын харьяалах Байнгын хороод энэ дээр анхаарч ажиллах ёстой.

П.Батчимэг: Б.Жавхлан сайд. 5 номерын микрофон.

Б.Жавхлан: Би О.Цогтгэрэл гишүүний асуултад нэмж мэдээлэл өгье.

Төсөв маань үндсэндээ 3 шаттай байдаг.

→ Засгийн газар төсвийг “төлөвлөх” үндсэн үүрэгтэй.

→ Улсын Их Хурал хэлэлцэн “батлах” эрхтэй.

→ Баталсан хуулийг нь Засгийн газраас “гүйцэтгэлээр хангах” үүрэгтэй.

Тэгэхээр өөрөө энэ яг төсөв гэдэг харилцаанд хэн орох вэ, ямар субъектүүд байх ёстой вэ гэдэг л хуулийн л ойлголт л доо.

Тэгэхээр төсвийн харилцаанд орж байгаа

▶ төсвийн ерөнхийлөн захирагч нар болон тэд нарын хоорондын харилцаа,

▶ төсвийн тусгай шаардлагууд,

▶ зарчим,

▶ тухайн жилийн болон дараагийн 2 жилийн төсөөллүүдийг

“төсөв” гэж байгаа юм. Үндсэндээ 4 хэсгээс бүрддэг.

Үүнийгээ өнөөдөр бид ярилцаад, хэлэлцээд сууж байгаа юм.

Тэгэхээр одоо Засгийн газрын бүтцэд байдаг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хяналтын үүргийг нь гүйцэтгэдэг, түүний харьяанд байдаг төрийн өмчийн үйлдвэрийн газрууд нь төсөвтөө.../минут дуусав/

П.Батчимэг: Б.Жавхлан сайдад 1 минут.

Б.Жавхлан: Тийм. Одоогоор яг шууд төсөвтэй холбогддог сүү нь ерөөсөө ногдол ашиг л байгаа юм.

Бусад нь Компанийн тухай хууль болон бусад холбогдох хуулиар төсөвт шууд хамааралгүйгээр явж байгаа юм.

Саяын аудитын орлогч даргын хэлдэг тэр дүгнэлт бол арай өөр агуулгатай дүгнэлт шүү.

Тэгэхээр цаашаадаа үүнийг ер нь яаж зохицуулах ёстой юм бэ гэдгийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс бидэнд маш тодорхой ирүүлсэн. Тэр дагуу бид ажлаа эхэлчихсэн байгаа.

Тэр нь юу вэ гэхээр Хөрөнгө оруулалтын тухай хууль.

Тэгэхээр тэндээс

► *улсын төсвөөр юу хийх юм,*

► *төрийн өмчийн үйлдвэрийн газрууд ямар хөрөнгө оруулалтууд хийж байх ёстой юм,*

► *төр, хувийн хэвшлийн түншлэлээр аль хэсгийг нь хийх юм,*

► *орон нутгаас альныг нь хийх юм, альныг нь гаднын шууд хөрөнгө оруулалтаар хийх юм*

гээд эх үүсвэрүүдийн боломжит хуваарилалтуудыг хуульчилж өгөх ийм чухал хууль дээр бид суугаад эхэлсэн байгаа.

Тийм учраас энэ хууль дээр бүгдээрээ Засгийн газар, Улсын Их Хурал хамтарч ажлаа эхлүүлээд богино хугацаанд, хойтон төсөв өргөн баригдах

үед энэ хууль аль хэдийн хэрэгжээд эхэлчихсэн байх ийм цаглавартай явахаар төлөвлөж Засгийн газар ажилдаа орсон байгаа шүү. Тийм.

П.Батчимэг: Ч.Лодойсамбуу гишүүн асуултаа асууя.

Ч.Лодойсамбуу: Ажлын хэсгийнхэндээ оройн мэнд хүргэе.

Б.Жавхлан сайд аа. Сая Ж.Ганбаатар гишүүн хэллээ л дээ.

Ер нь жил болгон бид энэ нэг төсвийн зардлыг ярьдаг гэж.

Одоо хамгийн сүүлд хоёулаа ярилцаж байсан. 2022 оноосоо би ингээд тоог нь харьцуулаад харж байгаа юм л даа.

Монгол Улсын төсвийн нийт зарлага 2022 онд 18.2 их наяд. Энэ нь 2025 онд 35.8 их наяд.

Хөрөнгийн зардлын хэмжээ нь 5.1 их наядаас 9.8 их наяд.

Урсгал зардал нь 13.3 их наядаас 26 их наяд.

Тэгээд энэ нь өөрөө төсөвт урсгал зардал, зарлага нь нэмэгдэнэ гэдэг бол өөрөө “бид бүтээгч улс биш” гээд та бид 2 жилийн өмнө сүүлд ярилцлага хийж байхад Та бүтэн санал нэг байна. Энэ төсвийн шинэчлэлийг бид хийх ёстой гээд л хэлээд л байж байсан.

Энэ 9.8 их наядын хөрөнгийн зардал, энэ 26 их наядын урсгал зардал чинь ерөөсөө л тэр чигтээ бүтээгч биш хэрэглэгч, импортлогч улсын хувьд тэр чигтээ л валютын ханшийн өсөлт, инфляц шүү дээ.

Тэгээд жил болгон бид үүнийг яриад л, энэ байдлаасаа бид ер нь гарахгүй юм уу?

Тэгээд бид сая мөнгөний бодлого хэлэлцээд байж байхад Монголбанкаа бид бөөн бөөндөө загнаад л сууж байсан.

Монголбанк нь дангаараа яг энэ төсөвтөө л захирагдаад, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ мөнгөний хатуу бодлогоосоо гарахгүй. Бизнесүүд нь явдаггүй.

Энэ төсвийнхөө бодлогоор бид өөрсдөө бизнесээ, эдийн засгаа ингэж татаж унагадаг байдлаасаа ер нь хэзээ гарах юм бэ?

Төсвийн шинэчлэлийн шинэчлэлийн тухай ярьж байсан. 2 жилийн өмнө хамгийн сүүлд уулзаж байхад л ярьж байсан.

Сангийн сайд аа, ер нь бид энэ тойргоосоо ер нь гарах юм уу, гарахгүй юм уу?

Бизнесүүдээ татаж унагадаг. Бизнесүүд чинь ер нь таны үед нар үзэх юм уу?

Одоо жишээлбэл татварын орлогоор, төсвийн орлогын бүрдүүлэлтээр харахад аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас 2025 онд 7.5 их наяд, хувь хүний орлогын татвараас 2.9 их наяд төгрөг 2025 онд, дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татвараас 3.4 их наяд гэх мэтчилэн.

Орлого нь нэмэгдэж байгаа гэж ярьж байгаа л даа.

Гэтэл бодитоороо бид ханшийг нь өсгөөд, инфляцыг нь өсгөөд хаячихаар

чинь тэр компанийн орлого нэмэгдэх бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлээд ч гэдэг юм уу, орлого нь нэмэгдэж байгаа боловч ашиг нь өсөхгүй шүү дээ.

Ашиг өсөхгүй байна гэдэг чинь өртөг нь нэмэгдээд ашиг нь өсөхгүй болохоор чинь яг өрхөд очиж байгаа дэмжлэг, өрхийн амьжиргаа чинь эцсийн дүндээ сайжрах ёстой юм байгаа биз дээ. Монголын төр үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд.

Бид эндээс ер нь гарах юм уу? Жил болгон яг ингээд л. Өнгөрсөн хугацаанд хоёулаа ярилцлага хийснээс хойш юу болсон бэ гэхээр инфляц 16 хувьд хүрсэн, долларын ханш 3500-г хүргэж үзүүлсэн.

Тэр үед та бас л өнөөдрийнх шиг ямар ч асуудалгүй л гээд л яриад л байж байсан шүү дээ.

П.Батчимэг: Ч.Лодойсамбуу гишүүний асуултад Сангийн сайд.

Б.Жавхлан: Ч.Лодойсамбуу гишүүний асуултад хариулья.

Ерөнхий бодлогын асуулт байна гэж ойлголоо.

Өнгөрсөн 4 жил амаргүй 4 жил байлаа. Бид нэлээн хүнд сорилт дундуур явж ирсэн. Үүнийг би хямрал гэж хэлмээргүй байна. Энэ том сорилт байсан.

Биднээс шалтгаалсан зүйл багатай. Дэлхий нийтийг хамарсан КОВИД, үргэлжилсэн геополитикийн асуудал гээд.

Манайх шиг “гадаад худалдааны эдийн засагтай улс”-ын хувьд бидэнд маш эмзэг туссан. Маш эмзэг туссан.

Бид дотоодын хэрэглээнийхээ 70, 80 хувийг импортоор авдаг. Ганц зах зээлээс хамааралтай экспорттой ийм улсын хувьд маш том сорилт, хайчин дунд орсон.

Инфляц 16 хувь бид максимум хүрсэн. Хүрсэн.

Энд гаднаас импортолж ирж байгаа инфляц ч байгаа юм. Мөн дотоодын манай дэд бүтэц, нэвтрэн өнгөрүүлэх чадвар гээд бусад зүйлээс хамааралтай ийм инфляцын ч нөлөөллүүд байсан.

Түүнээс биш энэ дээр төсвийн бодлого, мөнгөний бодлогоос шууд хамааралтай “мөнгөний бодлого”, “төсвийн бодлого”-д номхордог тийм “инфляц” тэр үед байгаагүй.

Харин одоо цаашаагаа эдийн засаг маань тогтворжиж ирээд эдийн засгийн өсөлтийн энэ үед харин бид инфляц төсвийн ашигтай, алдагдалтай байдал, төлбөрийн тэнцэл дээрээ маш болгоомжтой энэ төсвийнхөө тэлэлтийг орцыг нь тааруулж, эдийн засгийнхаа өсөлтийг нь дэмжиж явах ийм л сорилтод бид шилжчихээд байгаа юм. Шилжээд байгаа юм.

“Төсвийн урсгал зардал” гэж байна.

Төсвийн урсгал зардал үүнийг ямар нэг хийсвэрээр зохиогдоод гарч ирдэг зардал ерөөсөө огтоос биш. Урсгал зардлын нэг төгрөг болгоны цаана төрийн үйлчилгээ байж байдаг.

Төсвийн бодлогын үндсэн 2 зорилт байдаг.

***Нэгдүгээрт**, төрийн үйлчилгээг “тасралтгүй санхүүжүүлэх” үндсэн үүрэгтэй.*

***Хоёрдугаарт**, эдийн засгийнхаа хөгжлийг дэмжих.*

Ийм үндсэн хоёр суурь шаардлага байдаг.

Тэгэхээр суурь зардал дээр сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа зүйлүүдийг би түрүүн Ж.Ганбаатар гишүүний асуултад хариулахдаа хэлсэн. Дахиад хэлье.

Энд үндсэндээ эдийн засгийн 3 ангилал байгаа юм.

Нэгдүгээрт, шууд автоматаар тавигдаж байгаа 3 шалтгаан байна.

- ▷ Хүн амын статистик өсөлт,
- ▷ Инфляц,
- ▷ Тариф.

Үүгээр шууд автоматаар нэмэгдэж байгаа.

Хоёрдугаарт, цаана нь бас 2 том шалтгаан байна. Тэр нь Засгийн газраас ер нь өргөн баригдаагүй дээ.

Одоо бид 30 гаруй хуулийн дагуу шууд төсвөө нэмэгдүүлэх, зардал нэмэгдэх заалттай, зохицуулалттай.

Салбар болгоны үйл ажиллагаа, онцлогуудыг тусгасан зүйлүүдийг санхүүжүүлэх үүрэг хуулиар хүлээж байгаа юм.

Гуравдугаарт, үндэсний томоохон хөтөлбөрүүд байна.

Энэ бол одоо яг КОВИД-оос хамааралтай. Тэндээс бид сургамж авсан. Дараагийн КОВИД тулахад, дараагийн дайн тулаан тулахад бид энэ үндэсний аюулгүй байдал, ард иргэд маань эдийн засгийн болон нийгмийн баталгаатай байх ёстой.

Энэ рүү чиглэсэн томоохон үндэсний хөтөлбөрүүдийн санхүүжилтийн нэмэгдлүүд нь нийлээд ерөөсөө **3.5 их наяд** болж байгаа.

Нэмэгдэж байгаа зөрүү нь **1.7 их наяд** нь яг төсвийн хөрөнгө оруулалтын нэмэгдэж байгаа зардал. Ингээд энэ жилийн зардлаас хойтон 2025 оны зардлын өсөлт 5.3 их наяд нь ерөөсөө л яг ийм бүрэлдэхүүн хэсэгтэй болж ирж байгаа.

Эндээс одоо юу гэдэг юм, урсгал зардлаас энэ нь илүү юм байна, үүгээр тухайн төсвийн үйл ажиллагаа, Засгийн газрын үйл ажиллагааг санхүүжүүлэх шаардлагагүй юм байна. Үүнийг нь зогсоогоод энэ зардлыг нь бууруулъя гэдэг энэ эрх нь Улсын Их Хурал дээр байж байгаа.

Засгийн газраас төсвийн ерөнхийлөн захирагч нараас нийт ирүүлсэн хүсэлт нь бүр 10 их наяд гараад явчихсан байдаг юм.

П.Батчимэг: Ч.Лодойсамбуу гишүүн тодруулга.

Ч.Лодойсамбуу: Тийм. Яг л ингэж хариулдаг л даа. Аягүй олон ярилцлага яг ингээд л явсан. Тэгээд тэрийгээ л дахиад давтаад хийж байна.

Төрийн үйлчилгээ авах ёстой. Төрийн үйлчилгээг үзүүлэх ёстой.

Тэгээд тэр зарлага нэмэгдээд байгаа нь эргээд л төр нь төсвөө батлахдаа л нөгөө л инфляцдаа уягдаад л, нөгөө л төгрөгийн ханшийн сулралд уягдаад л яваад байна шүү дээ.

Энэ тойргоос хэзээ нэгэн цагт гарах юм уу л гээд байхгүй юу. Эдийн засгаа жоохон тэлэх юм уу, тэлэхгүй юм уу? Ингээд хумиад байх юм уу. Хумиад байгаа шүү дээ. Бүр байхгүй болгож байгаа шүү дээ.

Бизнес эрхлэх боломж байхгүй. Өрхийн орлого нь нэмэгддэггүй.

Нэг талдаа хөрөнгө оруулалт замаар аж ахуйн нэгжүүдийг мөнгөжүүлээд яваад байгаа боловч нөгөө талдаа инфляц, ханшийн өсөлт чинь айл өрхийн орлого, тэр компаниудын ажил хийж байгаа хүмүүсийн нөгөө талын халааснаас нь энэ ханшийн өсөлт чинь татаад л, инфляц нь татаад л авч байна шүү дээ.

Өрхөд очиж байгаа үр дүн алга байна. Үүнийг бүгдээрээ зөндөө ярьсан. Та ч хүлээн зөвшөөрсөн.

Бүр нэг тодорхой жишээ дурдсан шүү дээ. 1995 онд Монгол Улсын төсөв 150 тэрбум байсан юм байна. Өнөөдрийнхтэй харьцуулахад 200 дахин өссөн байна.

Өрхийн орлого 30 орчим, 30 дахин өссөн. Энд төрийн явуулж байгаа үйл ажиллагаа нэг л буруу байгааг тодорхой тоо өөрөө хэлж байгаа шүү дээ.

Үүнийг Та өөрөө хүлээн зөвшөөрч байсан шүү дээ. Тэгээд эндээсээ гарах юм

уу л гээд байгаа байхгүй юу. Эндээсээ гарах юм уу. Хэзээ гарах юм. Таны үед гарах юм уу, танаас өөр Сангийн сайдтай болж байж гарах юм уу?

П.Батчимэг: Ч.Лодойсамбуу гишүүний тодруулгад хариулт хангалттай юу?

5 номер. Сангийн сайд.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмж хариулъя.

Зарим нэг зүйлүүдтэй нь санал нийлэхгүй байна. Буруу ойлголцсон юм болов уу даа. Би л буруу ойлгуулсан байлгүй. Бодвол.

Ирэх 4 жилийнхээ төлөвлөгөөг Та өөрөө оролцоод, бид баталсан байгаа.

Ирэх 30 жилийнхээ хөгжлийг тодорхойлж харж байгаа. Бүсчилсэн хөгжил болон бидний сүүлийн 34 жил эдийн засгийнхаа өсөлтүүдийг боомилж ирсэн, ялангуяа дэд бүтцийн асуудлуудаасаа бид сууриа тавьж, шилжилтээ хийе гэж байгаа.

Энэ удаагийн төсөв ерөөсөө л тийм юм байгаа шүү дээ.

Бид жилдээ 450-аас 500-аад шинэ төсөл орж ирдэг байсан бол ирэх жил ерөөсөө 38 төсөл л байгаа.

Энэ 38 төслийн чинь үзүүр дээр хувийн хэвшил, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтуудаар л бий болох тэр баялаг бүтээгч, тэр боловсруулах үйлдвэр, тэд нарыг л дэмжих ийм дэд бүтцүүд байгаа.

Эрчим хүч зам, тээвэр. Энэ нь орон нутаг руугаа чиглэсэн кластерлаж хөгжих.../минут дуусав/

П.Батчимэг: Б.Жаргалан гишүүн асуулт.

Б.Жаргалан: Та бүхэнд оройн мэнд хүргэе.

Тэгэхээр Төсвийн хэмнэлтийн тухай хууль гэдэг нэртэй хууль үйлчилж байгаа энэ цаг мөчид 5.3 их наядаар төсвийн зарлага ороод ирж байгаа талаар яах вэ, гишүүд зарлага өсөж байгаа тал дээр зөндөө л ярилаа.

Б.Жавхлан сайд төсөв дотоодын нийт бүтээгдэхүүнийг тэлэх үржүүлэгчийн үүрэг гүйцэтгэх ёстой гэсэн үндэслэлээр зөвтгөж байгаа. Тийм ээ.

Тэгэхээр би нөгөө талаас нь ярья гэж бодлоо л доо.

Тэгэхээр төсвийн зардал тэлж байгаа явдал ер нь хувийн хэвшилд хэрхэн яаж нөлөөлөх вэ? Тухайлах юм бол урсгал зардал тал дээр байгаа төсвийн худалдан авалт хэчнээн хувийн хэвшлийн бараа, бүтээгдэхүүнийг төсвийн худалдан авалтаар худалдаж авах вэ ч гэдэг юм уу. Тийм ээ. Энэ томоохон бүтээн байгуулалтын төслүүд дээр ямар ямар салбарын хэчнээн дотоодын аж ахуй нэгжүүд оролцох вэ?

Ер нь энэ тал дээр яг төсвийн шууд оролцоотойгоор хэчнээн дотоодын аж ахуйн нэгжүүд ажилтай орлоготой болох вэ гэдэг нэг асуулт байна.

Хоёрдугаарт, инфляцтай уялдуулаад төрийн албан хаагчдын зардлыг 6 хувиар нэмэгдүүлж байгаа. Энэ

нь хөдөлмөрийн зах зээлд хэрхэн яаж нөлөөлөх вэ гэдэг хоёр дахь асуулт Б.Жавхлан сайдаас асууя.

Хоёрдугаарт нь, Эрчим хүчний яамнаас асууя. Сүүлийн үед эрчим хүчний асуудал маш хурцаар тавигдаад байна шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр сар гаруйхны хугацааны өмнө 2024 оны төсвийн тодотгол дээр эрчим хүчний үнэ, тарифыг чөлөөлөх шилжилтийн зардал гээд 131.1 тэрбум тавьчихсан байж байгаа. Энэ 2025 оны төсөв дээр бас яг адилхан тайлбартай 50.0 тэрбум төгрөг тавигдаад ороод ирчихсэн байна.

Тэгээд нийт 181.1 тэрбумаар шилжилтийн зардал гэсэн дотаци байгаа юм л даа.

Тэгэхээр үүнийг яг ямар байгууллагууд дээр яг ямар арга хэлбэрээр олгож байгаа вэ? Энэ дээр бүр яг тодорхой хариулт өгнө үү. Тийм ээ. Одоо тухайлах юм бол энэ байгууллагад тэдэн төгрөгийн дотаци олгож байгаа гээд.

Гуравдугаарт, Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд аялал жуулчлалын асуудал орж байгаа. Аялал жуулчлал манай уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх чухал салбар байгаа.

Тэгээд Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд гээд тусдаа бас ийм бүтэц бий болсон.

Энэ сайдын төсвийн багцын нийт зардал нь 598.0 тэрбум төгрөг байна. Цалингийн зардал нь ганцаархнаа 16.8 хувь өсжээ.

Тэгэхээр инфляцтай уялдуулсан өсөлтөөс илүү өндөр байгаад байна.

Тэгэхээр орон тоогоо нэмээд байна уу, яагаад байна?

Тэгээд энэ урсгал зардлын багц дээр нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж гээд 65.0 тэрбум төгрөг байна. Үүний задаргааг нь харгах гэсэн юм.

Өмнө нь аялал жуулчлалаа сурталчилж байна гээд Influenсer-г зараад байсан мөнгө.../минут дуусав/

П.Батчимэг: Б.Жавхлан сайд. Микрофон 5

Б.Жавхлан: Б.Жаргалан гишүүний асуултад хариулъя.

Ер нь яах вэ, улсын төсөв дээр урсгал зардал талдаа ч тэр, гадаадын зээл, тусламжийн ашиглалт талдаа ч тэр, хөрөнгө оруулалт талдаа ч тэр, эцсийн дүндээ энэ яг хувийн хэвшил дээр л очдог. Эцсийн нэг төгрөг болгон.

Хөрөнгө оруулалт талын болон худалдан авалт талаас нь Та асууж байна.

Тэгэхээр яг хөрөнгө оруулалтын чиглэл дээр шууд болон шууд бус, туслан гүйцэтгэгчээр ч гэдэг юм уу, ер нь 10 мянга гаруй аж ахуй нэгжүүд улсын төсвийн хөрөнгө оруулалтан дээр тодорхой хэмжээгээр оролцож байдаг. Дамжаад дамжаад тэнд санхүүжилт авч байдаг гэсэн үг.

2023 оны тооцооллоор бид 45 мянган ажлын байр хадгалж чадсан. 2023 онд шүү.

Харин ковидын үед энэ тоо улам их өндөр гардаг.

45 мянган ажлын байрыг улсын төсвийн хөрөнгө оруулалт болон худалдан авалтаар дамжиж ажлын байрыг хадгалжээ гэсэн тооцоо статистик байна.

Ирэх жил ч юу байх вэ, ер нь цаашдаа бид Төрийн албаны тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулиар урсгал зардал талдаа гол хоёр суурь зардал болдог энэ “цалингийн зардал” болон “нийгмийн даатгалын тэтгэврийн хэмжээн” дээр бид үнийн өсөлттэй уялдуулж шууд нэмж байх ёстой гэсэн хуулиараа ийм үүрэг авсан.

Энэ дагуу ирэх жил 6 хувиар нэмж байгаа. Энэ нь мэдээж төрийн албаны тогтвор суурьшилтай байлгах бодлого дээр нэлээн чухал эерэг нөлөө үзүүлнэ гэж харж байгаа.

Үүнтэй холбоотой Үйлдвэрчний эвлэл, гурван талтын асуудал гарч ирдэг.

Сая төсөв өргөн барьснаас хойш гурван талтын хэлэлцээр хийгдээд шийдвэр нь гарчихсан уу. Тийм ээ. 798 мянган төгрөг болж нэмэгдсэн байгаа. Ийм мэдээлэл өгье.

П.Батчимэг: Эрчим хүчний Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх. 2 номерын микрофон.

Н.Тавинбэх: Гишүүний асуултад хариулъя.

2024 оны төсвийн тодотгол дээр эрчим хүчний салбарт зориулж 131.4 тэрбум төгрөг баталж өгсөн.

Эрчим хүчний салбарын 2004-2005 оны үнэ, тариф нэмэгдэх хүртэл бэлэн мөнгөний урсгалын дутагдалд орсон. Санхүүгийн их хэмжээний алдагдалтай ажиллаж байгаа нөхцөлд өвөлжилтийн бэлтгэл хангах ажилд зориулж энэ мөнгийг олгосон байгаа.

Би танд энэ дотацийг юунд зарцуулсан талаар дэлгэрэнгүй мэдээллийг бичгээр явуулъя. Нэлээн дэлгэрэнгүй тайлан гарна.

Нүүрсний аваарын нөөц бэлдэх, нүүрсний уурхайнуудын өр авлагыг барагдуулах гэх мэтчилэнгээр өвөлжилтийн бэлтгэл ажилд шаардлагатай зардлуудыг бэлэн мөнгөний урсгалын дутагдлаас болж эх үүсвэргүй болсон зардлуудыг санхүүжүүлэхэд зарцуулсан байгаа гэдгийг хэлье.

2025 оны төсөв дээр тавигдсан 50 тэрбум төгрөгийн хувьд.../минут дуусав/

П.Батчимэг: 2 номер гүйцээж хариулъя.

Н.Тавинбэх: 50 тэрбум төгрөгийн хувьд эрчим хүчний үнэ, тариф нэмэгдсэний дараа нөлөөллийг арилгах зорилгоор энэ мөнгийг зарцуулахаар төлөвлөсөн байгаа.

П.Батчимэг: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас хариулах хүмүүс байна уу? Байхгүй байна.

Б.Жаргалан гишүүн тодруулъя.

Б.Жаргалан: Тэгэхээр харин ингээд сайд нараас асуулт асуух гэхээр хүмүүс нь байдаггүй, яамдынх нь хүмүүс байдаггүй. Дандаа ийм бүдүүн тоймын дүнгээр яриад байна л даа.

Тэгээд л одоо бүр бүдүүн тоймын дүн нь болохоор бүр хэдэн 100 тэрбумаараа яригддаг болчихсон. Тэгээд л тэрийг нь дараа нь мэдээлэл өгнө гэгчхээд төдийлөн ирэхгүй байгаа.

Тэгэхээр Б.Жавхлан сайдад тусгайлан захирад Тендерийн тухай хууль дээр ч гэсэн одоо жишээлбэл төрийн худалдан авалтаар дотоодын үйлдвэрлэлээр хийгдэж байгаа бараа, бүтээгдэхүүн худалдаж авахад давуу эрх олгох энэ тэр гээд л заалтууд байгаа шүү дээ. Тийм үү?

Тэгэхээр тэрийгээ нэлээн сайн барьж ажиллаад. Одоо аль болох төсвийнхөө зардлын тэлэлтийг дотоодынхоо аж ахуйн нэгжүүдэд өгмөөр байна шүү дээ. Тэгэхгүй сүүлийн үед гаднаас ажиллах хүч төлбөргүй авна тэр гээд л яриад байгаа.

Тэгэхээр ямар хардалт байна вэ гэхээр баахан гаднын компаниуд орж ирээд л одоо энэ бүх төсвийн чинь мөнгийг зарцуулаад дуусах юм байна гэсэн тийм хүлээлт байгаад байна.

Тэгэхээр одоо жишээл дараа нь “ажлын байр хадгалж байна” гэж ярихгүй, “нэмэгдүүлж байна” л гэж яримаар байгаа юм л даа. Тийм.

Одоо ирэх жилүүддээ ажлын байр хадгалсан гэж ярихгүй, тэдэн ажлын байр нэмэгдүүлсэн гэж яримаар байгаа юм аа гэж байгаа байхгүй юу. Санал.

П.Батчимэг: Л.Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Нэг асуулт байгаа юм.

Тухайн төсвийн ерөнхийлөн захирагч нарын гаргаж байгаа төсвийн зардал тус бүрээр нь төсвийн үржүүлэгчид тооцдог уу гэдэг нэг асуулт байгаа юм.

Одоо өөрөөр хэлбэл Эрчим хүчний яамны гаргаж байгаа зардлын Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн үзүүлж байгаа нөлөө нь арай нэг өөр байна байх. Тийм үү. Зам, тээврийн яамных арай өөр байгаа байх.

Иймэрхүү тооцоо байдаг уу гэж нэг асуумаар байна.

Ер нь бид “инфляц”-тай уялдуулаад “урсгал зардал”-ыг холбоод байгаа учраас “зардал байнга өсөж явна”.

Тэгвэл нөгөө талдаа энэ “зардлыг бууруулах”, “бүтээмж нэмэгдүүлэх” талаар ямар ажил хийгдэж байгаа вэ гэдэг мэдээллийг ялангуяа төсвийн төсөл дээр оруулж өгдөг болмоор байна.

Тэгэхгүй болохоор тухайн төсвийн ерөнхийлөн захирагч бүр дээр хэдэн хүний орон тоотой байж байгаад одоо хэд болж байгаа юм, нэг хүний гаргаж байгаа зардал нь хэд байгаа юм, бүтээмж нь яаж сайжирч байгаа юм гэдэг иймэрхүү мэдээллийг цаашдаа оруулж явах нь зөв байх гэсэн нэг ийм саналыг хэлье гэж бодож байна.

Тэгээд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны төсвийн төсөл дээрээс хөрөнгийн зардал дээр 40.0 тэрбум төгрөгийн “бусад хөрөнгө” гээд нэг заалт байх шиг байна. Энэ нь ямар зориулалттай зардал вэ гэж асуух гэсэн юм.

П.Батчимэг: Ц.Туваан сайд.

Ц.Туваан: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам төсвийн орлого бүрдүүлэлтийн бараг гуравны нэгээс илүү хувийг бүрдүүлж байгаа.

Зардал дээр 2 зардал байгаа. Энэ дотор байгаа “хөрөнгийн зардал” дээр байгаа 40.0 тэрбум төгрөг бол гадаадын улс орнуудад хэрэглэгддэг, Монгол Улсад төдийлөн хэрэглэгддэггүй агаарын “соронзон хайгуул”-ын зардлыг өмнөх 2 жилд тавьж ирсэн.

Энэ соронзон хайгуул онгоцоор хийгддэг, зардал ихтэй хайгуул байдаг. Тэгээд 3 дахь жилдээ үргэлжлүүлээд явж байгаа.

Тэгээд энэ хайгуулыг цааш нь үргэлжлүүлэн хийнэ. Дээрээс нь тайланг нь буюу олон улсын жишигт нийцэхүйц тайлангуудыг нь бид бүхэн цаашдаа сонгон шалгаруулалтын талбай болон бусад мэдээлэлдээ хэрэглээд явах юм гэж хариулья.

П.Батчимэг: Л.Соронзонболд гишүүн. Тодруулга байна уу? Сангийн сайд. 5 номер.

Б.Жавхлан: Л.Соронзонболд гишүүний асуултад хариулья.

Төсвийн ерөнхийлөн захирагч бүр дээр. Яах вэ, салбар салбар л гэж ойлгох хэрэгтэй л дээ.

Оруулж байгаа хөрөнгө оруулалт, урсгал зардлууд нь дотоодын нийт бүтээгдэхүүн хэрхэн яаж нөлөөлдөг вэ гэж асуулаа.

Тэгэхээр үүнийг тооцоололгүй яах вэ. Тухайлбал, энэ индекс дээр хамгийн өндөр байгаа нь манай эрчим хүчний салбар байгаа юм.

Өөрөөр хэлбэл 4.16 гэсэн индекс 2025 онд гарч ирж байна. Юу вэ гэхээр эрчим хүчний салбарт оруулсан 100 төгрөг болгон дотоодын нийт бүтээгдэхүүний 416 төгрөг болж очно гэсэн үг.

Нөгөө талдаа, эсрэг талдаа хамгийн бага нь мэдээж боловсролын салбар байгаа. Боловсролын салбар нь маань яг тоон илэрхийллээрээ ийм шүү. Төсвийн.

Түүнээс биш бусад хөгжлийн индексээрээ ирээдүйд баялаг бүтээгч иргэдийг болон нийгмийн хөгжлийн суурь асуудлуудыг мэдээж боловсрол, соёл, шинжлэх ухаан гээд урт хугацаандаа нөлөөллүүд нь өндөр байдаг. Үүнийг буруу ойлгочих вий.

Тийм учраас одоо.../минут дуусав/

П.Батчимэг: Б.Жавхлан сайд гүйцээж хариулья.

Б.Жавхлан: Тэгэхээр эрчим хүч маань ийм өндөр индекстэй болчихсон байна гэдэг маань нөгөө талаараа яг эдийн засгийн хамгийн боомилж байгаа ийм хязгаарлагчийн хүчин зүйл болчихоод байгаа гэдгийг нь харуулж байгаа байхгүй юу.

Одоо Улаанбаатар хотод нэмж ямар ч үйлдвэр байгуулах боломж эх үүсвэр байхгүй байна. Нэмж байшин хороолол, орон сууц барих боломж байхгүй болж ирж байна.

Тэгэхээр бидний ирэх жилийн төсөв дээр хийсэн бодлого эрчим хүч рүүгээ чиглүүлье гэж байгаа нь үүнтэй шууд холбоотой байгаа юм.

Энэ чинь өөрөө хамаг юмыг үнэхээр боомилгогч болчихсон байгаа учраас дунд, урт хугацаандаа бид эдийн засгийнхаа хөгжлийг, хувийн секторын хөрөнгө оруулалт, баялаг бүтээгч нар, боловсруулаад бусад бүх салбаруудын өрсөлдөх чадварыг нэмье гэвэл ерөөсөө хамгийн том индекстэй эрчим хүч рүүгээ л бид гол анхаарах ёстой болж байгаа юм.

П.Батчимэг: Л.Соронзонболд гишүүн тодруулах уу? Л.Соронзонболд гишүүн тодруулъя.

Л.Соронзонболд: Төсвийн төслийн “хүрэх үр дүнгийн чанар болон тоон үзүүлэлтийг хэмжих” гээд хүснэгт байгаа шүү дээ. Тийм ээ.

Түүн дээр гол нь хүний нөөцтэй холбоотой мэдээллийг оруулдаг болох.

Тэгээд -

▷ нэг ажилтанд ногдож байгаа зардал нь яам болгоноороо хэд байгаа юм,

▷ бүтээмж нь яаж нэмэгдэж байгаа юм,

▷ ямар хэмжээний зардлын хэмнэлт хийж байгаа юм бэ

гэдэг мэдээллийг оруулдаг байх тийм санал гаргаж байгаа шүү.

П.Батчимэг: Л.Соронзонболд гишүүн санал хэллээ.

Г.Лувсанжамц гишүүн асуулт.

Г.Лувсанжамц: Эрхэм төрийн түшээдэд оройн мэндийг хүргэе.

Эхний асуулт нь болохоор Б.Жаргалан гишүүний асуулттай ойролцоо.

Ер нь төсөв орж ирэхдээ багцаараа нэр нь “Бүсүүдэд” гэсэн төслүүд орж ирээд байна л даа.

Жишээлбэл, Эдийн засгийн хөгжлийн яамны 2 дугаар хавсралтын 4.1.4, 1.4.1 дээр. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зураг төсөв гээд 40.0 тэрбумын багц байна. Энэ нь яг хаана нь юм бол? Бүсүүдэд гээд биччихсэн байгаа. Хаана хөрөнгө оруулаад юу хийх гэж байгаа юм бол?

Хот байгуулалтын яамны 2 дугаар хавсралтын 18.1.1. Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц. Бас бүсүүдэд гээд. Тэгээд 64.0 тэрбум.

Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр 1 дүгээр үе шат. Бас бүсүүдэд гээд 30.0 тэрбум төгрөг.

Нийлүүлэнгүүт 100 гаруй тэрбум төгрөг болчхож байгаа юм.

Яг хаана, хэдийг зарцуулах юм бэ? Зарим төсөл, хөтөлбөрүүд нь аль суманд гэдэн километр зам ч юм уу. Тийм ээ. Тийм байдлаараа тусаад байгаа болохоор бусад бүсүүдэд гэж бөөрөнхийлж байгаа юмнуудыгаа нарийвчлаад бичиж өгнө үү гэж би хүсэж байна.

Тэгээд яг ямар агуулгатай байгааг нь хариулна уу гэж эхний асуулт байгаа юм.

Хоёр дахь нь, Эдийн засгийн байнгын хороон дээр “20 минут”

Үндэсний хорооны ажлын албанаас хүмүүс байлгамаар байгаа юм.

Нэгэнт хотын асуудал бид хэлэлцдэг болохоор 20 минутын хорооноос юу хэрэгжүүлэх гэж байгаа вэ гэдэг асуултууд байгаа юм. Жишээлбэл, 1 дүгээр хавсралтын 38.1.1, 38.1.2 зорчилтын судалгаа, тандан судалгаа, 2 дугаар хавсралтын 7.4 дээр ТЭЗҮ гээд нийтдээ 20.0 тэрбум төгрөг тавьчихсан байгаа.

Нийслэлтэйгээ хэрхэн уялдаж ажиллаж байгаа юм бэ? Хот байгуулалтын яамтайгаа хэрхэн уялдаж байгааг нь мэдмээр байгаа болохоор байлцвал зүгээр байна гэсэн тийм санал байна.

Дараагийн асуулт нь, Эдийн засаг, хөгжлийн яамнаас бас адилхан хавсралт 18.1.1.1 дээр “дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын орчин тодорхой болсон байна.” гэсэн зорилт тавьсан байна.

Үүнийг их зөв гэж бодож байна. Сайшааж байна.

Төсөл, хөтөлбөрүүдийг үр ашгаар нь эрэмбэлээд “тэргүүн ээлжийн төсөл” гээд тавьж орж ирээд, төсөв дээр байгаа зарим нэг 3 үе шаттай төсөл, хөтөлбөрүүд байгаа шүү дээ. Тийм ээ.

Түүн шиг дунд хугацаандаа бид төсөвлөдөг болох хэрэгтэй байгаа учраас Сангийн яамтай төлөвлөгөөгөө боловсруулахдаа хамтарч ажиллаад, тэргүүн ээлжид хэрэгжүүлэх төслүүдийнхээ эрэмбийг гаргаж болох уу гэдэг хоёрдугаар асуулт.

Гурав дахь нь, ихэнх гишүүд хэлж байна л даа. **“KPI”** /Key Performance

Indicator/ гээд. Хувийн хэвшил бүгдээрээ хэрэглэдэг болчихсон шүү дээ. “Кэй Пи Ай” гээд.

Нэг ажилтныг ажилд авснаараа тэр компанийн ашиг орлого хэр их нэмэгдээд байгаа юм бэ, буураад байгаа юм уу, ер нь энэ компани сайжраад байгаа юм уу, эсвэл уруудаад байгаа юм уу гэдгийг хэмждэг. Тийм ээ.

Манай төр дээр болохоор тийм юм байхгүй, ингээд зарим зүйлүүд нь доголдолтой харагдаад байгааг засъя гэсэн санаа сая Л.Соронзонболд гишүүнээс, бас Б.Жаргалан гишүүн хэлж байна л дээ. Энэ аягүй чухал болохоор хэдүүлээ цааш цаашдаа аль аль талаасаа үүнийгээ шаардаад явъя гэж бодож байна.

Үндэсний аудитын газар, Статистикийн ерөнхий газар энэ дээр орж ирэх болов уу гэж бодож байна.

Жишээлбэл, алдаатай үзүүлэлтүүд хэд хэд байгаа. Би дараа нь цаг авч байгаад яг дэлгэрэнгүй хэлье.

Үндэсний статистикийн хороон дээр 14.1.4 дээр. Хавсралт 1. Тийм ээ. Холбогдох салбарын үзүүлэлтийн аргачлалыг шинэчилнэ гэж байгаа. Олон улсын шалгуурыг ашиглах гэж байна уу? Ямар байдлаар хийх гэж байгаа юм бол? Нарийвчилсан төлөвлөгөөг сонсмоор.../минут дуусав/

П.Батчимэг: Г.Лувсанжамц гишүүний эхний асуултад Эдийн засаг, хөгжлийн яам. 3 номер

И.Батхүү: Г.Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

Эдийн засаг, хөгжлийн яамны
Төрийн нарийн бичгийн дарга.

2025 оны улсын төсвийн төсөл дээр байгаа Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад байгаа 40.0 тэрбум ТЭЗҮ, зураг төсвийн төслийн задаргааг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нар тухайн салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлага, ач холбогдол, түүнтэй холбогдох танилцуулгын мэдээллийнх нь саналыг аваад таны дурдаж байгаа төсөл эрэмбэлэх аргачлалын дагуу хамгийн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай төслүүдийн жагсаалт гаргаад 40.0 тэрбумдаа багтаагаад эрэмбэлээд оруулдаг.

Хугацааныхаа хувьд төсөв зарцуулах эрх нь үүссэний дараа тушаалаар задаргаа нь гардаг.

Ер нь Эдийн засаг, хөгжлийн яамнаас улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслүүдийг боловсруулах аргачлалыг ЖАЙКА олон улсын байгууллагатай хамтарч боловсруулсан. Энэ аргачлалынхаа дагуу Сангийн яамтай хамтраад цаашдаа хэрэгжүүлэх төслүүдийг эрэмбэлэх, үнэлэх ажлыг хийх бүрэн боломжтой байгаа.

П.Батчимэг: Хот байгуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Баярбат. 2 номер дээр хариултаа өгнө үү.

Ц.Баярбат: Г.Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны газрын дарга Ц.Баярбат.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд тусгагдсан нийт хөрөнгө оруулалт, бүсүүдийн хөгжлийг дэмжих, инженерийн шугам сүлжээ дэд бүтцийн чиглэлээр нийтдээ 213.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байгаагаас 2025 онд 63.9 тэрбумыг суулгаад байгаа.

Одоо энэ дээр ямар нэгэн задаргаа хийгдээгүй. Бид яаман дээр орон нутгаас холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх саналууд ирсэн. Үүнийг бид Төсвийн тухай хуультай нийцүүлээд зураг төсөл нь батлагдсан, төсөвт нь магадлал хийгдсэн ажлуудад хуваарилахаар төлөвлөж ажиллаж байна.

Энэ бол холбогдох Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээтэй нийцүүлж эрэмбэлэгдэж цаашид явна.

П.Батчимэг: Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа. 2 номер дээр.

Б.Батдаваа: Г.Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

Үндэсний статистикийн хорооны төсвийн ерөнхийлөн захирагчийн шалгуур үзүүлэлтэд орсон үзүүлэлтүүд дээр хуулиар Статистикийн тухай хууль болон Хүн ам, орон сууцын тооллогын тухай хуульд заасан үзүүлэлтүүдийг Статистикийн байгууллага тооцож гаргах хэрэгтэй байдаг.

Энэ дагуу бид Нэгдсэн Үндэстний Байгууллага болон дотоодын төр болон хувийн хэвшлийн байгууллагуудаас хэрэгцээ шаардлага дээрээ үндэслээд олон улстай харьцуулагдахуйц арга,

аргачлалын дагуу салбаруудын аргачлалуудаа шинэчлээд явдаг.

Ирэх жилийн гол хийгдэх ажил дотоодын нийт бүтээгдэхүүнийг “суурь оны тооцоолол”-оос “хэлхээ индексийн тооцоолол”-д шилжүүлэх аргачлал явж байгаа.

Энэ бол статистикийн чадавхаараа дээгүүрт ордог байгууллагуудын хийх ёстой нэг шилжилт гэж үзээд бид энэ дээр зорилт болгоод явж байгаа.

П.Батчимэг: Г.Лувсанжамц гишүүн тодруулъя.

Г.Лувсанжамц: Тодруулга дээр КPI-тай холбоотой тодруулмаар байгаа юм.

Жишээлбэл, Эрчим хүчний яаман дээр хавсралт 1.33.1.5 дээр “гэр хорооллын айл, өрхүүдэд цахилгааны хөнгөлөлт үзүүлэх, хөнгөлөлт өгөх өрхийн тоо 210 мянга байгааг 2025 онд 223 мянга болгоно” гээд хөнгөлөлт, дотаци өгөх зорилго болчихсон юм шиг харагдаад байгаа юм.

Уг нь энэ чинь “утааг бууруулах” зорилт шүү дээ. Тийм ээ.

Утааг бууруулахын тулд цахилгаан халаагуур ашиглуулахын тулд хөнгөлөлт олгож байгаа учраас “утааг хэдэн хувиар буулгах юм бэ” гэсэн. Үр дүнг нь тэгж хэмжих ёстой байгаа.

Үүнийг нь Үндэсний аудитын газар, Статистикийн хороо хоёр бас анхаарвал зүйтэй болов уу гэж бодож байгаа.

Дараагийнх нь болохоор Зам, тээврийн яаман дээр хавсралт 1.26.1.1

дээр “товлолт хугацаанд техникийн үзлэгт хамрагдах байдлыг нэмэгдүүлнэ.” гээд автомашины техникийн үндэслэлийг хэлээд байх шиг байна.

Одоо суурь түвшин нь 55.0 хувь гэснээ 2025 онд 75.0 хувь гэж байгаа юм. Энэ бүгдээрээ орох ёстой шүү дээ. Тийм ээ. 100 хувь байх ёстой шүү дээ.

Үдээс өмнө Санхүүгийн зохицуулах хороон дээр ярьсан юм. Жолоочийн хариуцлагын даатгал гэж юм байгаа. Ер нь үзлэгтээ ордоггүй жолооч нарыг бараг хариуцлагын даатгалыг нь нэмээд ч юм уу. Тийм ээ. Тийм арга хэмжээ авахгүй бол хамгийн хариуцлагагүй, соёлгүй, автобусны зогсоол дээр очоод тавьчихдаг, энд тэнд машинаа тавьчихаад дугаараа тавьдаггүй тийм хүмүүсийн толгойг нь илээд яваад байж болохгүй болов уу гэж бодож байгаа болохоор ийм салбар хоорондын уялдаа, зорилтууд, шалгуур үзүүлэлтүүдийгээ уялдуулж өгөөсэй гэж бодож байна.

Соёлын яаман дээр байгаа юм. Хавсралт 1 дээр 35.7.1. “соёлын салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.” гэсэн мөртлөө “нийт хөдөлмөрийн насны 20 хувь нь соёлын салбарт ажиллана.” гээд тавьчихсан.

5 хүний 1 нь бараг дуулж хуурдаад яваад яваад байя гэсэн нэг тийм зорилт харагдаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр дотоодын нийт бүтээгдхүүнд эзлэх хувь ч байдаг юм уу, экспортод эзлэх хувь ч байдаг юм уу. Тийм ээ. Тиймэрхүү зүйлүүдээ хэрэгжүүлээсэй гэж бодож байна.

Тэгээд хот дээр economist intelligence ашиглаад цаашдаа төлөвлөөсэй гэж бодож байна.

П.Батчимэг: Эрчим хүчний яам, Зам, тээврийн яам.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд манай Байнгын хорооны.

Асуулт нь Соёлын сайд дээр. Тийм ээ. Өнөөдөр энд ямар ч төлөөлөл ирээгүй байна. Уг нь бүгдэд нь хурлын зар хүргэсэн байгаа. Тийм.

Уг нь бүгдэд нь хурлын зар явуулсан байгаа. Өнөөдөр алга байна. Ирээгүй байна.

Эрчим хүч Н.Тавинбэх дарга хариулах уу. 2 номер.

Н.Тавинбэх: Засгийн газрын тогтоолын дагуу Улаанбаатар хотын гэр хороололд амьдардаг ахуйн хэрэглэгчдэд халаалтын асуудлаа цахилгаанаар шийдсэн тохиолдолд хүчдэлийн түвшнээс нь хамааруулаад 700 киловаттаас 1500 киловаттын хөнгөлөлтийг цахилгаан цахилгаан эрчим хүч хэрэглэсэн төлбөрийг төрөөс дааж байгаа.

Энэ бол агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ.

Засгийн газраас даадаг хэрэглэгчдийн тоо нэмэгдсэн шалтгаан Засгийн газрын журамд өөрчлөлт орсонтой холбоотой.

10 мянгаас дээш хүн амтай сум, суурин газарт амьдардаг гэр хорооллын ахуйн хэрэглэгчдийн шинэ хэрэглэсэн

цахилгаан эрчим хүчний төлбөрийг төрөөс хариуцдаг болсонтой холбоотой хэрэглэгчдийн тоо огцом нэмэгдсэн.../минут дуусав/

П.Батчимэг: Зам, тээврийн яам. 2 номерын микрофон дээр.

С.Батболд: Г.Лувсанжамц гишүүний асуултад хариулъя.

Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд.

Тантай санал нэг байна.

Ер нь авто тээврийн тухай хуулиар тээврийн хэрэгслийн бүртгэлийн системд байгаа нийт тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамрагдаж байж замын хөдөлгөөнд оролцох үүрэгтэй.

Хэрвээ ороогүй, тэнцээгүй байдаг юм бол замын хөдөлгөөнд оролцохгүй байх зохицуулалттай. Энэ дээр дээр санал нэг байна.

Даатгалын хувьд мөн тантай санал нэг. Бид Санхүүгийн зохицуулах хороо даатгалд тавьдаг. Сахилгагүй жолооч нар даатгалаас янз бүрийн нөхөн олговор аваад байдаг.

Тэгтэл яг дүрмээрээ явж байгаа. Тийм ээ. Даатгалаас эрсдэл гаргахгүй байгаа жолооч нарт бас урамшуулал олгооч ээ гэдэг асуудлыг бид тавьж байгаа.

П.Батчимэг: Манай эрхлэх ажлын хүрээнд Соёлын яам багтаагүй.

Г.Лувсанжамц гишүүн 1 минут.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Яг ямар учир шалтгаантайгаар хэлж

байгаагаа хэлж байгаад их талархалтай хүлээж авлаа.

Эрчим хүчний яам, Зам, тээврийн яам хоёр утааг бууруулах, түгжрэлийг бууруулах дээр том оролцоотой орох боломжтой төрийн байгууллага гэж бодож байгаа болохоор энэ зорилт дээрээ тавьсан зүйлийнхээ шалгуур үзүүлэлт дээр нь яг юуг зорьж байгаа гэдгийг бичихгүй бол энэ материалууд чинь бүгд интернэтээрээ ил байгаа шүү дээ. Тийм ээ.

Ингээд жоохон ухаад харах юм бол энэ одоо юуг зориод 223 мянган хүнд цахилгааны хөнгөлөлт олгоод байгаа юм, яагаад техник үзлэгтээ ордоггүй, тэгээд тэрний зорилтот түвшин 75 хувь байгаа юм гэсэн асуулт нийгмээс гарч магадгүй учраас цаашдаа ийм төлөвлөгөө, төсвийн бичиг баримтаа хийхдээ үр дүн дээр суурилсан байдлаар бичээд олон нийтэд хүргээсэй гэж хүсэж байна. Санал байлаа.

П.Батчимэг: Г.Лувсанжамц гишүүн санал хэллээ. Одоо Р.Батболд гишүүн асуулт асууя.

Р.Батболд: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Хоёрхон асуулт л асууя.

Эхнийх нь ер нь нэлээн давтагдчихсан асуулт. Сангийн яамнаас асуух гээд байгаа юм.

Бид тэнцвэржүүлсэн орлогоо 5 их наядаар нэмэгдэнэ гээд. Зарлагаа болохоор 5.3-аар нэмэгдэж байгаа гэж орж ирээд байгаа юм.

Ер нь сая 8 сард бид тодотголоор 27-г 30 болгоогүй бол энэ чинь түрүү жилийн 2024 оны батлагдсан төсвөөсөө 8 их наядаар л нэмэгдээд байх шиг байгаа юм гэж харагдаад байгаа юм.

Тэгэхээр нэмэгдээд байгаа зардлаасаа, урсгал зардал, хөрөнгийн зардлаасаа тэвчиж болох зардлыг нь хасаад, тэнцвэржүүлсэн тэнцлээ нольлоод, ингээд баланслуулаад оруулаад ирж болдоггүй байсан юм болов уу л гэж асуух гээд байгаа юм.

Тэгээд бид орлогын чинь дийлэнх хувийг нь нүүрсний экспорт эзлээд байдаг.

Тэгээд бид нарын үнэ дээр юм уу, эсвэл хэмжээн дээр нэг өөрчлөлт гарахад орлого маань өөрөө тасалдах ийм эрсдэлтэй юм биш үү? Үүнийг ер нь нэг жоохон баланслуулах тал дээр нь бодож үзвэл яасан юм гэдэг нэг санал байна. Ийм асуулт байгаа юм.

Хоёрдугаар асуулт нь, бас энэ нүүрсний экспорттой холбоотой. Хилийн нэвтрүүлэлтийг нь Зам, тээврийн яам хариуцаад байдаг юм уу? Боомтын сэргэлтийн хороо нь хариуцдаг юм уу?

Төмөр зам холбох асуудал нь ирэх жилдээ шийдэгдэж чадах юм уу? Тээвэр ложистикийнх нь асуудлыг 83 сая дээр аваачаад хийхэд яг хангалттай тийм нөөц байгаа юм уу гэдэг асуулт.

П.Батчимэг: Сангийн сайд 5 номер.

Б.Жавхлан: Р.Батболд гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр сүүлийн жилүүдэд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гээд бид бас ийм шинэ институцтэй боллоо. Мөн 2020 оноос хойш хоёр ч удаа бид Төсвийн хууль болон тусгай шаардлагууд дээр нэмэлт сайжруулсан ийм өөрчлөлтүүдийг хийлээ.

Тэгээд одоо бид ялангуяа төсвийнхөө орлого талыг төлөвлөхдөө бид маш их нарийн дэгтэй, журамтай, хуулийн зохицуулалттай болсон байгаа шүү.

Тэгэхээр ирэх жилийн тэнцвэржүүлсэн орлогод бидний нөлөөлөх яах вэ, түүхий эд талаас нь харах юм бол хоёр гол экспортын зүйл байгаа. Нүүрс, зэс гээд.

Энэ хоёрынхоо бид гол үнийг авахдаа зах зээлийн үнэ болон тэнцвэржүүлсэн үнийнхээ аль багаар нь авдаг. Өөрөөр хэлбэл хамгийн бага эрсдэлтэй байхаар авдаг гэсэн үг.

Жишээлбэл, зэсийг одоо зах зээлийн үнэ нь 10 мянган доллар байгаа юм. Тэнцвэржүүлсэн үнэ нь 7469.96 доллар.

Тэгэхээр бид аль багаар нь буюу 7500-гаар нь орлогоо тооцоолсон байгаа.

Өөрөөр хэлбэл өнөөдрийн зах зээлийн үнэ 10 мянга байгаа нь ирэх жил 2500 буюу 25 хувиар унахад зэсээс орж ирэх орлого маань тэнцвэртэй байна гэсэн үг.

Нүүрс дээр ч гэсэн адилхан. Нүүрсний зах зээлийн үнэ 105 доллар. Тэнцвэржүүлсэн үнэ нь 129 доллар.

Ингээд багаар нь буюу 105 доллараар авч байгаа гэсэн үг. Орлогоо.

Ингэж бид орлогоо төлөвлөдөг. Мөн энэ тэнцвэржүүлсэн орлогоос давсан хэсгээрээ бид өнөөдрийг хүртэл хуримтлал бий болгосон байгаа.

Энэ дээр бид Тогтворжуулалтын сан дээр 1.6 их наяд төгрөгийн хуримтлалтай. Ирэх жил 6 зуугаад тэрбум төгрөг мөн нэмэгдэж хуримтлал бий болно. Нийлээд 2.2.

Тэгэхээр энэ маань өөрөө орлогод нөлөөлөх ийм эрсдэл үүсвэл нөхөх ийм зориулалттай сангууд байгаа юм. Гэх мэтчилэн эрсдэлүүдээ хаасан ийм төсвийн зохицуулалтуудтай болсон байдаг.

Тийм учраас ирэх жилийн хувьд бидний төлөвлөсөн орлого тал дээр томоохон эрсдэл гарахгүй гэж харж байгаа.

Боомтын сайд хариулах уу. Тийм ээ. Тэр хилийн нэвтрэн өнгөрүүлэх чадварыг асууж байх шиг байна.

П.Батчимэг: Б.Тулга сайд.

Б.Тулга: Та бүгдийн оройн мэндийг хүргэе.

2024 оны байдлаар 10 сарын 1-ний тоо аваад үзэх юм бол яг нүүрсний гаралт, нүүрсний тээвэр хийж байгаа боомтууд дээр аваад үзэх юм бол 60.1 сая тонн. Өнгөрсөн онтой харьцуулахад 19 хувийн өсөлттэй байгаа юм.

Тэгэхээр энэ чигээрээ явна.

Ер нь 10, 11, 12 сарын хугацаанд бүтэн жилийн динамик аваад үзэх юм бол өсөлттэй явдаг.

Тэгэхээр гаралтын хэмжээ одоохондоо буурахгүй. Энэ чигээрээ яваад байх юм бол энэ ондоо багтаад 80 сая тонн орчим нүүрс Бүгд Найрамдах Хятад Ард Улсад борлуулж худалдах бололцоо байгаа.

Тэгэхээр 2025 оны төлөвлөгөө дээр яг 80-аараа тавьсан байгаа. Мэдээж энэ бол үнээс хамаарна. Хятадын талын эдийн засгийн өсөлтөөс шууд хамааралтай байгаа.

Зүгээр Хятадын эдийн засаг өөрсдөө 2025 онд төлөвлөхдөө 5 хувийн өсөлттэй байна. Энэ 5 өсөлтөө хангахын тулд Хятадын Засгийн газраас янз янзын бодлогуудыг, ялангуяа дэд бүтэц.../минут дуусав/

П.Батчимэг: 5 номер. Сангийн сайд.

Б.Жавхлан: Түрүүн дутуу хариултаа гүйцээе.

Р.Батболд гишүүн хэллээ. Энэ урсгал зардал болон бүтээн байгуулалтуудаа эрэмбэлж байгаад алдагдалгүй төсөв оруулж болдоггүй юм гээд.

Энэ болно л доо. Их амархан. Энэ бол маш амархан. Сонголтын л асуудал байгаа юм.

Бид 4 жилийнхээ төлөвлөгөөг батлаад, энэ хамтарсан Засгийн газрын үед бид нарыг үнэхээр боомилоод байгаа эдийн засгийн яг суурь дэд бүтцийн асуудлуудаа явуулъя гэж л ингэж шийдэж орж ирсэн байгаа.

Бүх бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарын бүтээн байгуулалтын ажлуудыг нэг жилээр хойшлуулж байгаад.

Тэгэхээр тэндээсээ л сонголтын асуудал байна. Эрчим хүч шаардлагагүй ээ, энэ зам шаардлагагүй гэвэл бид

алдагдлыг тэглээд оруулж ирэх маш амархан.

Ирэх жил 10.3 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтууд яригдана. Үргэлжилж байгаа болон шинэ нийлээд.

Монгол Улсын төсвөөс 4.3, гадаад зээл, тусламжаас 2.6, орон нутаг 3.5 гээд.

П.Батчимэг: Сангийн сайд 1 минут.

Б.Жавхлан: Тийм. Орон нутгийн 3.5-аас жишээ нь нийслэл дээр 1.7 их наяд байх жишээтэй.

Төсвийн алдагдал 1.9 их наядаар байгаа. Нэмэгдэж байгаа шинэ хөрөнгө оруулалтуудын зөрүү дүн нь 1.7 их наяд.

Тэгвэл шинээр ерөөсөө тэр зам эрчим хүчээ ерөөсөө больчихъё. Зөвхөн үргэлжилж байгаагаа л явуулъя. Бидэнд шинэ эрчим хүчний эх үүсвэр шаардлагагүй, шинэ зам хэрэггүй гэвэл тэгээд л алдагдалгүй гарчихна.

Төсвийн үзүүлэлтүүд бүгд сайжраад, төлбөрийн тэнцлийн үзүүлэлт сайжраад, ямар нэг бид төлбөрийн тэнцэл дээрээ сөрөг дарамтгүй, гадаад худалдаан дээрээ, бас импорт дээрээ сөрөг дарамтгүй ингээд аягүй амархан гараад явчихна.

Тэгэхээр энэ дээр л сонголтын асуудал байгаа юм. Энэ бүхнээс болгоомжлоод бид эдийн засгийн өсөлт дараа дараагийнхаа дунд, урт хугацааныхаа холын зорилтуудаасаа ухраад үүнийгээ царцаах л ийм л нөгөө талын эрсдэл үүснэ гэсэн үг. Тийм.

П.Батчимэг: Ц.Туваан сайд.

Ц.Туваан: Р.Батболд гишүүний асуултад нэмж хариулъя.

Энэ төмөр замын холболтын асуудал энэ Гашуунсухайт-Ганцмодны боомтын төмөр замын хил холболтын асуудал байгаа.

Энэ хил холболт орж байж. Мөн дараагийнхаа ээлжид Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээ, Бичигт-Хатавч гэсэн ийм дарааллуудаар явна гэсэн асуудлыг урд хөршийн талаас маань тавьж байгаа.

Тэгээд энэ замын холболт 2025 онд орох уу гэж асуусан.

Яг одоо ингээд Улсын Их Хурлаар тэр гэрээ хэлцэлтэй холбоотой асуудлууд тун удахгүй орж ирнэ.

Сая Ерөнхий сайдын айлчлалын хүрээнд Хятадын “Чайна Энержи” компанийнхантай уулзалт хийсэн. Ойрын хугацаанд Засгаар орж Их Хурлаар орж ирнэ.

Асуудалгүй шийдэгдээд явсан тохиолдолд 2025 онд орж амжихгүй. Тийм. Бас нэлээн гүүр, байгууламжийн асуудлууд байгаа.

П.Батчимэг: Р.Батболд гишүүн тодруулах уу? Б.Найдалаа гишүүн асуулт асууя.

Б.Найдалаа: Соёлын яамныхан байхгүй байгаа нь харамсалтай байна.

Соёлын сайд, Соёлын яамныхан Эдийн засгийн байнгын хорооны асуудалд хамаарна л даа. Бүр хамаарахаар барахгүй их хамаарахаар байна.

Та бүхэн бод доо. Одоо энд жишээлбэл яамдын яг бодлого барьж байгаа мэргэжилтнүүд, дарга нар, сайд нар байна.

Соёл урлагийн салбарт, спортын салбарт 485 тэрбум. Хагас их наяд төгрөг тавьчихсан байна. Тийм төсөл хэрэгжиж байна.

Энэ жил 165-ыг санхүүжүүлнэ. 2025 онд.

Нөгөө элгээрээ хэвтчихээд байгаа, цахилгаангүй болчихоод байгаа, тасарчхаад байгаа, шинэ орон сууц ашиглалтад өгөх боломжгүй болчихоод байгаа эрчим хүчний салбарт 600 тэрбум төгрөг. Бараг адилхан.

Тэгээд энэ жил 199 тэрбумыг зарцуулна. Эрчим хүчний салбарт. Тэгээд Та бүхэн үүнийг харьцуулаад бод доо.

Монгол Улс ямар бодлого бариад, хаашаа яваад байгаа юм бэ?

Тэгээд соёлтой холбоотой тоног төхөөрөмжийн зардал 24 тэрбум төгрөг.

Монгол Улс 2 долоо хоногт тэрбум төгрөг соёлын ч юм уу, спортын ч юм уу төхөөрөмж аваад байх нь л дээ.

Цахилгаангүй байж. Тоггүй байж. Иймэрхүү байдалтай л байна шүү дээ.

Тэгээд үүнийг Соёлын сайдаас би дараа нь асууя гэж бодож байна. Соёлын яамнаас асууна. Задаргаанд энд байхгүй юмыг чинь асуугаад яах вэ.

Зүгээр ганцхан асуулт. Сангийн яамтай холбоотой, бусад төсөв боловсруулдаг улстай холбоотой байж магадгүй.

Сум болгон шахуу соёлын төв барьж байгаа. Үүнийг би үгүйсгээгүй. Зөв.

Гэхдээ хуучин барилгуудаа яадаг юм бэ? Хэн нэгэн баланс дээр байж байгаа урсгал зардал гаргаад л явж байгаа даа. Тэр хаана байна? Тэр юунд ашиглах вэ? Тэр их сонин асуулт байна. Нэг ийм асуулт байна.

Хоёрт нь, энэ дээр хэдэн үйлдвэрлэл байна л даа.

→ *Бяслагийн үйлдвэр Хөвсгөлд байна. 1.4 тэрбум гэж байна.*

→ *Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн агро парк гэж байна. Сэлэнгэд байна.*

→ *Цөцгийн тосны ферм гээд байна. Тэшигт байна. 3.7.*

Хөдөө аж ахуйн кластер гээд янз янзын хувийн юм шиг ийм төслүүд байгаа байхгүй юу.

Төр ингээд хийгээд байдаг юм уу? Дэмжлэг юм уу? Юу нь тодорхойгүй байна.

Үүнийг би яагаад асууж байна гэхээр бодлого нь хаашаа явж байгаа нь сонин байна.

Хэрвээ энэ ингээд хийгээд болоод байх юм бол дараа нь тэр аймагт, энэ аймагт, энэ суманд гээд явчих юм бол бид яг соёлын төв шиг болчих байхгүй юу.

Үүнийг тодруулах яам нь тодруулж өгөөч.

Эцэст нь товчхон хэдэн юунууд байна. Сангийн яамтай хамаатай юм болов уу.

Энэ “Иргэдэд үйлчлэх төв” гээд. Би хөөгөөд үзсэн чинь нэршил нь 20 гараад алга болчихлоо.

▶ *Хүний хөгжлийн ордон,*

▶ *Хүүхэд залуучуудын хөгжлийн ордон,*

▶ *Хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн барилга,*

▶ *Ахмадын өргөө,*

▶ *Ахмадын хөгжлийн төв,*

▶ *Хүүхэд, залуучууд, ахмадын хөгжлийн төв,*

▶ *Соёлын төв,*

▶ *Соёлын цогцолбор*

гээд ингээд 20, 30 юм байна.

Энэ ямар стандарт байдаг юм? Хүүхдэдээ нэр өгч байгаа юм шиг өгөөд байдаг юм биш үү дээ.

Тэгээд энэ чинь яг ямар хамааралтай, ямар юм байдаг юм? Эмх цэгц нь байдаг юм уу, байдаггүй юм уу гээд. Үүнд тодруулж өгөөч.

П.Батчимэг: Б.Найдалаа гишүүн ээ, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны асуудлууд хамаарч байгаа. Тэнд асуудлыг ярьж байна лээ.

Б.Найдалаа гишүүний асуултад Сангийн сайд. 5 номер.

Б.Жавхлан: Б.Найдалаа гишүүний асуултад хариулья.

Байнгын хороодод хамрагдах яамдыг Улсын Их Хурал, Тамгын газар болон тэр хууль тогтоомжтойгоо нийцүүлээд л зохицуулчихдаг байгаа шүү.

Тэр соёлын төвтэй холбоотой. Яах вэ, ирэх жил Соёлын төв, спорт цогцолбор гээд тухайн сайдын эрхлэх ажилд хамаарагдах 60 гаран төслүүд үргэлжилнэ. Бүх сумдад ч биш л дээ.

Тэгэхдээ таны асууж байгаа асуулт, тэр хуучин барилгууд яах вэ гэхээр энэ бас нэг шалгуур үзүүлэлт нь болчхож байгаа юм.

Хэдэн жилийн насжилттай юм, түүн дээр нь зохих байгууллага нь очоод стандартыг нь тогтоогоод, норм нормативыг нь хараад цаашаа ашиглах боломжгүй гэвэл тэгээд л тэр чинь ашиглахгүй л дээ. Ашиглахгүй болоод л явчих байгаа юм.

Ашиглалтад байгаа, цаашид ашиглах боломжтой гэж акт гарчихсан, тодорхойлчихсон тийм барилга, байгууламж байгаа сумууд дээр шинэ хөрөнгө оруулалтууд тавигдахгүй. Энэ бас нэг шалгуур үзүүлэлт нь болоод явчихдаг гэсэн үг. Ийм л юм байгаа юм.

Жижиг, дунд үйлдвэрүүдийн хувьд таны саяын яригдсан зүйлүүдээс тэр 2 нь Засгийн газраас орж ирсэн төсөл биш. Улсын Их Хурал дээр яригдаж, хэлэлцэгдэж байх үед нэмэгдсэн төсөл болон тойргийн гишүүдээс ирсэн саналаар орсон ийм төсөл, хөтөлбөрүүд байна. Тийм.

Тэгэхээр жижиг, дунд үйлдвэрлэлийг хариуцдаг Ж.Энхбаяр сайд ч түрүүн Байнгын хороон дээр маш тодорхой хэлж байсан.

Одоо төр төсвөөс үйлдвэр барих энэ бодлогоос бид аль хэдийн татгалзсан.

Харин дэд бүтцийг нь, газрыг нь татварын бодлогоор баялаг бүтээгч нарын шат шатны үйлдвэрлэгч нарыг дэмжинэ. Тийм.

Тэгэхээр энэ бодлого цаашдаа ч тогтвортой үргэлжлээд явах юм байгаа юм.

“Иргэдэд үйлчлэх төв” хуучнаар Тамгын газар шүү дээ.

Тамгын газрын энэ байранд иргэдэд үзүүлэх үйлчилгээнийх нь цар хүрээ, үйлчилгээнийх нь төрөл нь улам л нэмэгдэж ч байгаа.

Тийм учраас ингэж нэрлэх нь илүү үйлчилгээтэйгээ уялдана. Зөвхөн аймгийн Засаг дарга, юу гэдэг юм тэр Тамгын дарга нь суудаг байшин биш, аль болох нэг цэг дээр бүх төрлийн үйлчилгээнүүд үзүүлэх боломжтой байх ийм л байгууламж байгаа юм.

Тийм учраас тийм нэртэй болж байгаа.

П.Батчимэг: Ж.Энхбаяр сайд нэмж хариулах уу? Ж.Энхбаяр сайдын микрофоныг өг дөө.

Ж.Энхбаяр: Б.Найдалаа гишүүний асуултад хариулья.

Энэ “цөцгийн тосны үйлдвэр”, “бяслагийн үйлдвэр” гээд өмнөх Их Хурлын үеэр гишүүдийн орон нутагт хуваарилсан хөрөнгө санхүүг ингээд жиргээд хуваасан тохиолдлууд манай Хөдөө аж ахуйн сайдын багцад нэлээн туссан байсан.

2022 онд хэрэгжээд, 2025 онд дуусахаар явж байгаа зүйл.

Энэ Засгийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн яам бол энэ бизнесийн аливаа үйл ажиллагаанд оролцохгүй гэж байр суурьтай байгаа.

Зөвхөн дэд бүтцийн бодлогын дэмжлэг үзүүлэх болохоос биш ахиж төрийн мөнгөөр, татвар төлөгчдийн мөнгөөр нэг тийм орон нутгийн чанартай жижиг цехүүдийг нээдэг.

Үүнийгээ улс төрийн зорилгоор ашигладаг, хөрөнгө үргүүлдэг, өмчийн ашиглалт эзэнгүүддэг.

Тэгээд аргаа бараад орон нутгийн өмчлөлд шилжүүлдэг. Цаашаа яаж ашиглалт нь, зардал нь яаж явж байгаа нь тодорхой биш. Ингээд орон нутгийн чанартай орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд олон арваар бий болж байгаа нэг ийм муу жишиг байсан.

Энэ бүгдийг дахин давтахгүйн тулд ийм.../минут дуусав/

П.Батчимэг: Ж.Энхбаяр сайд гүйцээж хариулья.

Ж.Энхбаяр: Тэгэхээр дахин ийм буруу жишгийг давтахгүй гэсэн байр суурьтай байгаа.

Мөн гишүүдэд нэг зүйлийг онцгой анхаарахыг хэлэхэд, төсвийн дундуур орж задалж, орон нутгийн чанартайгаар жиргэж задалдаг, төсвийг үймүүлдэг.

Тэгээд ийм зүйл ахин давтагдахгүй байх гэж найдаж байгаа бас илэрхийлье.

П.Батчимэг: Б.Найдалаа гишүүн тодруулах уу? Б.Найдалаа гишүүн тодруулья.

Б.Найдалаа: Энэ дээр тодруулах асуулт алга байна.

Түрүүний соёлын салбартай холбоотой нарийн юмыг дараа жич өөр Боловсрол, шинжлэх ухааны байнгын хороон дээр асууна.

485 тэрбумын, энэ жилийн 165 бол ихэвчлэн өнгөрсөн жилийн төсөв байна лээ л дээ.

Өөрөөр хэлбэл өнгөрсөн 2 жил 2024 оны төсвийг батлахад бодлогын алдаа хийсний гор. Одоо энэ чинь ингээд их наяд хүрнэ. Жилээс жилд өссөөр байгаад.

Өөрөөр хэлбэл бид их наядыг хүссэн хүсээгүй тэр соёл урлагийн байгууламжид хийнэ. Эргээд урсгал зардалд нь баригдана.

Тэгэхэд чинь юу гэсэн үг вэ гэхээр цаанаа эрчим хүчинд зарцуулах төсөв байхгүй.

240 сургууль Монгол Улсад дутуу байгаа шүү дээ. 240. Сургуулиа бариагүй байж соёлын төв барьсаар байгаад ийм бодлоготой улс болчихоод байгаа байхгүй юу.

Яах вэ, энэ жил нэг сайшаалтай нь шинээр тавиагүй байна лээ. Ганцхан хөрөнгө оруулалтын буруу алдаа эргээд 10, 20 жилийн зардлын, төсвийн ангальд унагадаг ийм аюултай байгаа юм.

Тийм болохоор энэ бол яг төсөв, ялангуяа хөрөнгө оруулалтад цаашдаа нэлээн сайн ярилцдаг. Сангийн яаман

дээр юм уу, эсвэл төсөв боловсруулж байгаа нэгж дээр төслүүдийг эрэмбэлдэг нэгж үнэхээр сайн байхгүй бол мөнгө байхад төсөл олддог, юу ч хамаагүй хийдэг. Ингээд бид яг улсаараа засраагүй байгаа байхгүй юу.

Тийм болохоор цаашдаа энэ дээр анхаарч ажилласан нь зөв байх. Баярлалаа.

П.Батчимэг: Б.Найдалаа гишүүн санал хэллээ.

Ш.Бадамсүрэн гишүүн алга байна. Гишүүд санал хураалтдаа оролцоорой. Санал хураалт явагдана.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Төсвийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс бичгээр ирүүлсэн саналуудаар санал хураалт явуулья.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.3-д зааснаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал гаргасан гишүүн саналынхаа үндэслэлийг тайлбарлаж үг хэлж болно.

Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд зардал шилжүүлэх санал.

1.Аудитын дүгнэлтийн Орон нутгийн төсвийн хэсэгт 1.1 тэрбум төгрөгөөр санхүү бүртгэлтэй холбоотой ажил гүйцэтгүүлэхээр тусгагдсаныг бууруулах хүрээнд Нийслэлийн суурь зардлыг 600.0 сая төгрөгөөр бууруулж, цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарах, цахилгаанд хүн цохиулахаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бий болгох

зориулалтаар Эрчим хүчний сайдын урсгал зардлыг 600.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг.

М.Энхцэцэг гишүүн саналаа хэлье.

М.Энхцэцэг: Сайн байцгаана уу? Та бүхэнд өдрийн мэндийг хүргэе.

Та бүхэн мэдэж байгаа. Сүүлийн үед цахилгаанаас үүдэлтэй гал түймэр гарч ард иргэд, аж ахуйн нэгж асар их хэмжээний хөрөнгө, санхүүгийн хохирол амсаж байгаа.

Шангри-Лад түймэр гарчээ л гэсэн, Их дэлгүүрт түймэр гарчээ л гэдэг. Хэдэн жилийн өмнө Алтжинд түймэр гарч байгаа. Энэ бүгд цахилгаанаас үүдэлтэй.

Ямар их хэмжээний хөрөнгө, санхүүгийн хохирлыг ард түмэн амссаныг бүгд мэдэж байгаа.

Мөн цахилгаан гүйдэлд хүүхэд, хүн цохиулж нас барах асуудал сүүлийн үед маш их гарч байгаа. Дархан хотод нэг айлын 3 хүүхэд цахилгаанд цохиулаад л нас барсан. Улаанбаатар хотод хүүхэд зүгээр л аптекийн хаалгыг онгойлгох гээд л бариулд нь гар хүрээд л нас барж байгаа асуудал өнөөдөр.

Тэгэхээр бид өнөөдөр ямар хүндээ ээлгүй аюултай тийм хотыг, тийм нийгмийг бүтээхээд байгаа вэ? Үүнийг засаж залруулахын төлөө бид юм хийх ёстой.

Тэгэхээр үүнийг засаж залруулахын тулд нам хүчдэлийн цахилгаан хангамж гээд. Яагаад гэхээр

маш онцлогтой. Хүн өнөөдөр гар хүрч ажилладаг, хүнтэй хамгийн ойр байдаг. Бид өнөөдөр разетка унтраалга гээд гар хүрч ажиллаж байдаг. Гүйдэл нь маш өндөр байдаг учраас тэнд ямар нэгэн богино залгаа гарах л юм бол хүн үхэх хэмжээний тийм аюултай байдаг учраас аюулгүй ажиллагааны түвшин маш өндөр түвшинд тавигддаг.

Тэгэхээр бид нам хүчдэлийн сүлжээний стандартыг орчин үеийн түвшинд болгож сайжруулах. Хамгийн гол чухал юм нь тэр стандартаараа хүмүүсийнхээ тархийг цэнэглэдэг тэр системийг буй болгох.

Жишээ нь, Австралийн их сургуульд нь бүхэл бүтэн нэг хичээл яг нам хүчлийн стандартаар хичээл ордог. Яагаад гэвэл стандарт гэдэг нь цаанаа нарийн онол байдаг. Тэр стандартаар хүмүүсийнхээ тархийг цэнэглэж байж өнөөдөр тэр стандарт бодит амьдрал дээр хэрэглэгддэг. Тэр стандарт хөгжлийг бий болгодог.

Тэгээд тэр стандартыг бодит байдал, нөгөө зураг төслийн байгууллагууд нь, барилга угсралтын байгууллагууд нь хэрэглэдэг. Бодит байдал нөгөө цахилгаан түгээх компаниуд нь, орон сууцын конторууд нь.

Энэ нам хүчдэлийн сүлжээний ашиглалтыг хариуцаж байгаа бүхий л байгууллага нь өнөөдөр байгаа байдал нь тэр ашиглалтын түвшин нь өнөөдөр тэр стандартыг хангаж байгаа юм уу. Тэнд богино залгаа гарахад тэр гүйдэл хүний биеэр гүйх юм уу, эсвэл тэр толгой дээр байгаа автоматыг ажиллуулах уу гэдгийг шалгаж сайжруулж байдаг тэр тогтолцоонууд бий болж байж өнөөдөр

бид хүндээ ээлтэй, аюулгүй тийм нийгмийг, тийм хотыг бий болгоно.

Тийм учраас энэ реформыг, энэ цогц тогтолцоог бий болгохын тулд энэ ажлыг тусгах нь зүйтэй байна гэдгээр гаргасан байгаа.

Тэгээд бууруулах төсвийн хувьд аудитын дүгнэлт гарсан байна лээ. Аудитын дүгнэлтийн хүрээнд нийслэл буюу орон нутгийн төсөв дээр 1.1 тэрбум төгрөгөөр санхүүгийн бүртгэлтэй холбоотой ажил гүйцэтгэхээр тусгасан байна. Энэ нь зах зээлийн ханшаас маш өндөр байна гэж тусгасан байсан учраас. Мөн нийслэл дээр 1.4 тэрбумаар шинэ жилийг тэмдэглэнэ, хүүхдэд ээлтэй орчин бий болгоно гэсэн зардлууд байсан.

Тэгэхээр зардлуудаас бууруулаад энэ төсвийг гаргаж реформыг хүндээ ээлтэй нийгмийг бий болгох, хотыг бий болгох нь зүйтэй юм гэдэг саналыг гаргасан байгаа.

Ингээд Та бүхэн маань дэмжиж өгөөрэй гэж хүсье.

П.Батчимэг: М.Энхцэцэг гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол дээр гишүүд санал хураалтаа эхлүүлье. Санал хураалт. /алх цохив/

М.Бадамсүрэн гишүүн. Микрофоныг нь өгье.

М.Бадамсүрэн: Минийх ажилласангүй. Би төхөөрөмжийг солих. Тийм. Хүчингүй болгоод дахин санал хурааж өгөөч. Энэ угаасаа ажиллахгүй юм байна.

П.Батчимэг: М.Бадамсүрэн гишүүний гаргасан горимын саналаар энэ

санал хураалтаа хүчингүй болгоё гэсэн санал хураалт. /алх цохив/

М.Бадамсүрэн гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэнгүй. 40 хувьтай.

М.Энхцэцэг гишүүн та өөрөө дэмжсэн учраас горимын санал гаргахгүй.

Дараагийн санал хураалт.

Хоёр.Зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн багцад тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд өөрчлөлт оруулах санал.

1.Төслийн 2 дугаар хавсралтад тусгагдсан ХХI.1.8.Налайх дулааны станцын хүчин чадлын өргөтгөл, 185 МВт /Улаанбаатар, Налайх дүүрэг/, Төсөвт өртөг 56,354.9 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 16,900.6 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2025-2027 он гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Налайх Дулааны шинэ эх үүсвэр, 216 МВт, /Улаанбаатар, Налайх дүүрэг/” гэж өөрчилж, уг төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг **18,000.0** сая төгрөгөөр нэмэгдүүлэх, эх үүсвэрийг дараах төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг бууруулах замаар шийдвэрлэх. Үүнд:

- “ХV.5.3.1. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын их өгөгдөл, цахим шилжилт, тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **2,000.0** сая төгрөгөөр,
- ХVI.1.1.7. Дархан-Алтанбулаг чиглэлийн хатуу хучилттай авто замын өргөтгөл 4 эгнээ, 113.1

километр, гүүрэн байгууламж 885.6 метр /Төвийн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **4,000.0** сая төгрөгөөр,

- ХVI.1.1.15. Хэрлэн-Тосон-Уул-Халх гол чиглэлийн хатуу хучилттай авто зам, 256 километр /Зүүн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **2,000.0** сая төгрөгөөр,
- ХVI.1.1.19. Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 66 километр /Баруун бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг **2,000.0** сая төгрөгөөр,
- ХVI.1.2.2. Даланзадгад-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай авто замын их засвар, 156 километр /Говийн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,000.0 сая төгрөгөөр,
- ХVI.3.1.1. Буйр нуур 4С нисэх буудлын зураг төсөв, барилга угсралт /Зүүн бүс/ гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 4,000.0 сая төгрөгөөр тус тус бууруулах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайхан. Санал хураалт. /алх цохив/

Санал дэмжигдсэнгүй. 20 хувиар санал дэмжигдсэнгүй.

Гурав.Зохицуулалт хийх санал.

Үүнийг миний бие Улсын Их Хурлын гишүүн Пүрэвийн Батчимэг гаргасан.

Энэ саналаа буцаалаа. Буцаж татлаа.

Дөрөв.Нэр өөрчлөх санал.

1.Төслийн 2 дугаар хавсралтад тусгагдсан XVIII.1.1. Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц /Бүсүүдэд/, төсөвт өртөг 213,199.2 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 63,959.8 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2025-2027 он гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалт-Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүдэд/” гэж өөрчлөх.

2.Төслийн 2 дугаар хавсралтад тусгагдсан XVIII.1.2. Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр 1 дүгээр үе шат /Бүсүүдэд/, төсөвт өртөг 90,000.0 сая төгрөг, 2025 онд санхүүжих дүн 30,000.0 сая төгрөг, хэрэгжих хугацаа 2025- 2027 он гэсэн төсөл, арга хэмжээний нэрийг “Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах цогц хөтөлбөр 1 дүгээр үе шат улс, аймаг, сумдын хамтарсан хөрөнгө оруулалт-Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүдэд/” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн.

М.Бадамсүрэн гишүүн саналаа тайлбарлая.

М.Бадамсүрэн: Энэ саналын хувьд улсын төсөвт ямар нэгэн өөрчлөлт юу ч байхгүй.

Зөвхөн улсын төсөв, аймаг, сумын төсөв гурван эх үүсвэрээс хамтраад тэгээд 12 жил хийх, бүх сумд орон сууц барих төслийг 3 жилд, 4 жилд багтаагаад хийе л гэж байгаа юм.

Өөрөөр хэлбэл энэ Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд, тэгээд Барилга, хот байгуулалтын сайдын эрхэлж байгаа ажлыг нь бүх сумд, Монгол Улсын 300 сумд үүнийг барьчихъя гээд.

Яагаад гэхээр Дорнод аймаг өөрийнхөө аймгийн төсвөөс 500 сая төгрөг гаргаад, сумаасаа 250 саяыг гаргаад тэгээд бид бүх сумдаа хийсэн юм.

Тэгээд үүнийг шийдсэнээрээ сумд байгаа төрийн албан хаагчдын дутагдалтай байгаа малын эмч, хүний эмч, багш, сувилагч гээд бүх орон тоо нөхөгдөхөд Монгол Улсын хэмжээнд хэрэгжүүлэх, улсын хэмжээнд хэрэгжүүлэх л төсөл болох гэж байна.

Тэгээд үүнийг нэг тийм судалгаагүй яриагүй. Дорнодод хийгээд болсон учраас бас энэ Их Хурлын, ялангуяа манай Эдийн засгийн байнгын хорооны хувьд энэ иргэдийнхээ чухал суурь болсон зүйлүүд дээр нэг ийм томоохон төсөл.

Орон сууц, тэгээд сумын инженерийн шугам сүлжээ гээд.

Тэгэхгүй бол яг үнэндээ зарим аймаг, сумдууд төсвөө яг тийм бодлогын томоохон юман дээр тавьж чадаж байна уу, үгүй юу. Эргэлзээтэй байгаа.

Тийм учраас бид улс юм болүүнийг удирдаад орон нутгийн хөгжлийн санд очиж байгаа нэлээд хэмжээний мөнгийг ингэж зөв төслүүдэд цаашдаа хамтарч явбал гурван эх үүсвэрээс. Нөгөө олон улсын төсөлтэй хамтраад Монголын талаас гарах хөрөнгө гэдэг шиг “улсаас гарах хөрөнгө” гэдэг томьёоллоор л үүнийг тэгж л өөрчилж өгч байгаа юм.

Тэгээд үүнийг дэмжиж өгөхийг
Байнгын хорооны гишүүдээсээ хүсье.

Монгол Улсын 300 сумд хэрэгтэй
зүйл шүү. Бидний 4 жилийн дараа аль ч
тойрогт, аль ч суманд очоод ярихад бид
санал гаргаж үүнийг дэмжиж батлуулсан
юм гэдэг ийм л чухал зүйл байгаа юм.
Дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

П.Батчимэг: Санал хураалт. /алх
цохив/

Санал 53.3 хувиар дэмжигдлээ.

Монгол Улсын 2025 оны төсвийн
төслийн талаарх зарчмын зөрүүтэй
саналуудаар санал хураалт явуулж
дууслаа. /алх цохив/

Монгол Улсын 2025 оны төсвийн
тухай, Үндэсний баялгийн сангийн 2025
оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын
сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл
мэндийн даатгалын сангийн 2025 оны
төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр
дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Төсвийн төслийн хоёр дахь
хэлэлцүүлгийг явуулсан талаар Эдийн
засгийн байнгын хорооноос гарах санал,
дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн
Ренчиндоржийн Батболд Төсвийн
Байнгын хорооны хуралд танилцуулна.

Эдийн засгийн байнгын хорооны
өнөөдрийн хэлэлцэх асуудал дуусаж,
хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Хуралдаанд идэвхтэй оролцсон
гишүүдээ баярлалаа.

Хуралдаан 2 цаг 09 минут үргэлжилж, 18 цаг 59 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД